



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Боржигон
Түмэнбаярын МӨНХГЭРЭЛ

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ НОТОЛГООНЫ
ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ



Мэргэжлийн индекс
042101

Эрх Зүйн бакалаврын зэрэг
Горилсон дипломын төсөл

Удирдсан
Ц.Даваасүрэн /LL.M/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Боржигон
Түмэнбаярын МӨНХГЭРЭЛ

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ НОТОЛГООНЫ
ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

В Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон дипломын Төсөл

Удирдагч: Ц.Даваасүрэн /LL.M/

Шүүмжлэгч: Д.Оюун /LL.M/

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЪЁГ

МЭДЭГДЭЛ.....	i
ТАЛАРХАЛ	i
ТОВЧ ХУРААНГУЙ.....	ii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	v
ОРШИЛ	1
Сэдэв сонгосон үндэслэл:	1
Судлагдсан байдал:	1
Сэдвийн тулгамдсан асуудал:	2
Судалгааны ажлын зорилго:.....	2
Судалгааны ажлын зорилт:	3
Судалгааны арга зүй:	3
Судалгааны шинэлэг тал:	4
Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:	4
I. БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ	5
1.1.Нотолгооны үе шат, шүүхийн нотолгооны тухай ойлголт	5
1.1.1. Нотолгооны үе шат, шүүхийн нотолгооны тухай ойлголт	7
1.1.2. Нотлох ажиллагаа ба нотолгооны хэрэгсэл	8
1.2.Шинжээчийн дүгнэлт нотолгооны хэрэгсэл болох нь.....	9
1.2.1. Шинжээчид тавигдах шаардлага, түүнийг сонгох ажиллагаа.....	13
1.2.2. Иргэний хэрэгт шинжээч томилох маргааны төрлүүд.....	15
1.2.3. Шинжээчийн дүгнэлтийн бүрдэл, тавигдах шаардлага	18
1.2.4. Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуур	20
Бүлгийн дүгнэлт:	22
II. БҮЛЭГ. ҮНДСЭН СУДАЛГААНЫ ХЭСЭГ	23
2.1. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тулгамдсан асуудал.....	23
2.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.....	28
2.3. Харьцуулсан судалгаа.....	44

2.3.1. Бүгд Найрамдах Герман улсын эрх зүйн зохицуулалт	44
2.3.2. Шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх	45
2.3.3. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтыг МУ-тай харьцуулах нь	48
ДҮГНЭЛТ	52
САНАЛ.....	56
НОМ ЗҮЙ.....	58

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (cc by-nc-nd) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Т.Мөнхгэрэл

Гарын үсэг:

Огноо: 2026/06/04

ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын зэрэг горилсон дипломын ажлын хүрээнд удирдан чиглүүлж, заавар зөвлөгөө өгсөн багш Ц.Даваасүрэн, шүүмжлэгч багш Д.Оюун мөн өөрийн мэдлэг, мэргэжлийн зөвлөгөөг харамгүй хүртээсэн СЭЗИС-ийн хууль зүйн сургуулийн багш нар болон бүхий л талаар минь дэмжиж, итгэж ирсэн гэр бүл, найз нөхөддөө гүн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажил нь онолын хэсэг болон үндсэн судалгааны хэсэг гэсэн 2 үндсэн бүлгээс бүрдэнэ. Онолын хэсэгт иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт, шинжээчийн дүгнэлт гэж юу болох, нотолгооны хэрэгсэл болохын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар байр суурийг эзэлдэг, шүүх шинжилгээний байгууллага болон шинжээч болон түүний үүрэг хариуцлага, шинжээчийн дүгнэлтэд тавигдах шаардлага болон бүрдэл, шинжээчийг томилох маргааны төрлүүд болон, шүүх хэрхэн үнэлдэг тухай суурь ойлголтуудыг багтаасан болно.

Үндсэн судалгааны бүлэгт шинжээчийн дүгнэлттэй холбоотой сүүлийн жилд шүүхэд түгээмэл тохиолдож буй маргаан, тэдгээрээс дурьдвал худалдах худалдан авах гэрээний зүйлд шинжээчийн дүгнэлт гаргах, зээлийн гэрээ, хөрөнгийн үнэлгээний зөрүүтэй маргаанд шинжээчийг томилох зэрэг маргааныг түүвэрлэж, шат шатны шүүхүүд тухайн маргааныг хэрхэн шийдвэрлэсэн, хуулийг хэрхэн тайлбарлаж үндэслэж байна вэ зэрэг шинжээчийн дүгнэлтийн ач холбогдлыг судлахаас гадна ХБНГУ-ын шинжээчийн дүгнэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг агуулсан болно..

Түлхүүр үгс: *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, шинжээч, шинжээчийн дүгнэлт, нотлох баримт, нотлох ажиллагаа, нотлогооны хэрэгсэл, үнэлэх, хариуцлага, ашиг сонирхлын зөрчил, шүүх шинжилгээ, дахин шинжилгээ*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судлагдсан байдлын тойм	1
Хүснэгт 1. 1. Шинжээч томилох маргааны төрлүүд.....	15
Хүснэгт 1. 2. Шинжилгээг хийлгэх шаардлага.....	16
Хүснэгт 1. 3. Үнэлгээ тогтоолгох маргааны зарим төрөл.....	17
Хүснэгт 2. 1. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь.....	23
Хүснэгт 2. 2. Хоёр улсын хууль тогтоомжийн харьцуулалт	48

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 2. 1. Шинжээч томилуулах хүсэлтийн шинжилгээний төрөл.....	24
Зураг 2. 2. Шинжээч томилсон маргааны төрөл (2015 оны байдлаар).....	28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ИХШХША	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ШШТХ	Шүүх шинжилгээний тухай хууль
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ХАҮТ	Худалдаа аж үйлдвэрийн танхим
ШУ	Шинжлэх ухаан

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн гол онцлог нь нотлох баримт цуглуулах, талууд байр сууриа хамгаалах мэтгэлцэх зарчмын хүрээнд явагддаг. Нэхэмжлэлч түүний төлөөлөгч, өмгөөлөгч нэхэмжлэлийнхээ үндэслэл шаардлагыг, хариуцагч хариу тайлбараа нотлох, хамгаалах замаар оролцдог билээ. Талууд иргэний процесс ажиллагаанд оролцоходоо хуульд заасан эрхийг эдэлж үүргийг хүлээдэг. Үүнд талууд тусгай мэдлэг шаардлагатай баримт болон нотлох баримтыг тодруулахын тулд шинжээчийг хүсэлт гарган томилуулдаг.

Иргэний хэргийн маргаанд тусгай мэдлэг шаардсан үйл баримтыг тогтоох хэрэгцээ улам нэмэгдэж байгаа тул шинжээчийн дүгнэлтийг нотолгооны хэрэгсэл болохын хувьд бодитой тогтоох, түүнийг үнэлэх эрх зүйн зохицуулалт зэрэг нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал ач холбогдолтой хэмээн үзэж энэхүү сэдвийг сонгосон болно.

Судлагдсан байдал:

Шинжээч томилох нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү түгээмэл байдаг байх ба харин иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч томилсон, шинжээчийн дүгнэлттэй холбоотой судалгаа болон эрдэм шинжилгээний ажлыг судалж үзэхэд Монгол улсын хүрээнд дараах бүтээлүүдэд тусгагдсан байна.

Хүснэгт 1. Судлагдсан байдлын тойм

Судлаачийн нэр	Бүтээлийн огноо	Судалгааны арга	Бүтээлийн нэр	Товч агуулга
Б.Буянзаяа, Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа, Б.Туул	2022 он	Харьцуулалтын арга	“Шүүхийн шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх эрх зүйн зохицуулалт: гадаадын зарим орны туршлага” Парламент судалгааны эмхэтгэл	ОХУ, Эстони болон, Франц улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн.
А.Доржсүрэн	2023 он	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон шүүмжит аналитик	“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлтийн ач холбогдол,	Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар асуудлыг тодорхойлохыг зорьсон байх ба шинжээчийн

			тулгамдаж буй зарим асуудал” Эрдэм шинжилгээний өгүүлэл	дүгнэлтийг нотолгооны чухал хэрэгсэл гэж үзсэн.
Б.Лхагвасүрэн	2018 он	Задлан шинжлэх	“Шинжээчийн дүгнэлтэд нотлох баримтын тусгай шалгуур тавих асуудал” Эрдэм шинжилгээний өгүүлэл	Эрүүгийн процессийн эрх зүйд шинжээчийн дүгнэлтийн байр суурь болон шалгуур ямар байгааг судлажээ.
Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн	2015 он	Түүвэрлэлтийн арга болон урьдчилан бэлтгэсэн асуултын дагуух асуумжийн арга	“Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” Бодлогын судалгаа	Энэхүү судалгаа нь эрүү, иргэн, захиргааны хэрэгт шинжээч дүгнэлт гаргах маргааны төрөл тоон статистик үзүүлэлтүүдийг гаргаж ирсэн судалгаа боловч иргэний хэргийн хувьд бичиг үсэг нь тайлж унших боломжгүй байдлаар нийтлэгдсэн байна.

Сэдвийн тулгамдсан асуудал:

ИХШХША-н дахь шинжээчийн томилох нь хэрэгт ач холбогдол бүхий гэж үзэж шинжээч томилдог маргааны төрлөөс дурдвал хөрөнгийн үнэлгээ хийлгэх, үнэлгээг хүчингүй болгох маргаан байдаг. Нэг хөрөнгө дээр өөр өөр шинжээчийн гаргасан үнэлгээний дүн зөрүүтэй гарч байгаа нь шүүгч дүгнэлтийг үнэлж шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг. Энэ нь шүүгчийн дотоод итгэл үнэмшлээр нотлох баримтыг үнэлэх боломжийг хязгаарлаж, хэргийн оролцогчдын зүгээс шүүхийн шийдвэрт эргэлзэх үндэслэл болж байна.

ИХШХШТХ-ийн 80.1.8-д зааснаар шинжээч томилсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг. Гэвч хөрөнгийн үнэлгээ хийх явц удаашрах, талууд үзлэг хийхэд саад учруулах, эсвэл шинжээч дүгнэлтээ хугацаандаа гаргахгүй байх зэргээс шалтгаалан хэрэг шийдвэрлэх ерөнхий хугацаа сунаж, иргэдийн шүүхээр эрхээ хамгаалуулах эрх хөндөгдөж байна. Энэ нь дахин болон нэмэлт шинжилгээ хийлгэх, шинжээч томилох шаардлага үүсгэдэг.

Судалгааны ажлын зорилго:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинжээчийн дүгнэлтийн эрх зүйн зохицуулалт, түүнийг нотолгооны хэрэгсэл болгон ашиглах, үнэлэх үйл явцад

тулгарч буй практикийн асуудлуудыг тодорхойлж, шинжээчийн дүгнэлтийн гүйцэтгэх үүрэг, нотолгооны ач холбогдлыг ерөнхий онолын хүрээнд тодорхойлж, улмаар шүүхийн практикт шинжээчийг томилох, дүгнэлтийг үнэлэх явцад тулгарч буй асуудлуудыг тодорхойлон, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны ажлын зорилт:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинжээчийн дүгнэлтийн онол, эрх зүйн зохицуулалтыг судлах
- Шинжээч томилох шүүгчийн захирамжид тавигдах шаардлага, процессын онцлогийг тодорхойлох
- Шүүхийн практик дахь үнэлгээний зөрүүтэй байдал, аргачлалын алдаанаас шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох
- Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шүүгчийн арга зүй болон холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах.

Судалгааны арга зүй:

Юун түрүүнд эхний бүлэг болох онолын хэсэгтээ тодорхой мэдээллүүдийг нэгтгэн найруулан бичсэн.

Ярилцлагын арга нь харилцан ярилцлагын тусламжтайгаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлдэг хууль зүйн судалгааны аргын нэг төрөл бөгөөд урьдаас бэлтгэсэн асуултын дагуу оролцогч сонгож бүтэцлэгдсэн ярилцлагыг хийсэн болно.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар асуудлыг тодорхойлохыг зорьсон бөгөөд ингэхдээ задлан шинжлэх болон дедукцийн аргыг ашигласан. Задлан шинжлэх арга нь бүхэл зүйлийг дэлгэрүүлэн үзэх, өөр хоорондын харилцан хамаарлыг тодорхойлж гаргах ач холбогдолтой судалгааны арга юм. Харин тодорхой сонирхсон сэдвийн хүрээнд хэлэлцдэг, онолоос цааш таамаглал дэвшүүлэн түүнийгээ шалгах, нотлох байдлаар дедукцийн аргыг ашиглана.

Судалгааны ажлын сэдвийн хүрээнд бичсэн онол болон судалгааны үр дүнг бүлгийн дүгнэлт болгон, мөн бүх агуулгыг багтаан ерөнхий дүгнэлт болгон нэгтгэн дүгнэж бичсэн ба ийнхүү бичихдээ нэгтгэн дүгнэх болон индукцийн аргыг ашигласан.

Судалгааны шинэлэг тал:

Энэхүү судалгааны ажил нь шинжээчийн дүгнэлт нотолгооны хэрэгсэл болохын хувьд хүрээнд шүүхийн гурван шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, уг дүгнэлтийг яг одоо цаг үед үнэлэхэд тулгамдаж буй асуудал болон шүүгчийн шийдвэр гаргах ажиллагаанд шинжээчийн үзүүлэх бодит нөлөөллийг практик талаас нь тодорхойлсноороо шинэлэг талтай болно.

Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:

Иргэний процессын эрх зүйн нотолгооны онолд "тусгай мэдлэг"-ийг ашиглах, шинжээчийн дүгнэлтийг нотолгооны бусад хэрэгслээс ялгах онолын үзэл баримтлал болон процессыг танин мэднэ.

I. БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Нотолгооны үе шат, шүүхийн нотолгооны тухай ойлголт

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт баталгаажуулж өгсөн байна.¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй нь аливаа иргэн, хуулийн этгээдийн зүгээс эдийн болон бус баялагтай холбоотой, тухайлбал үнэт зүйл эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах² зорилгоор шүүхэд хандах, хөндөгдсөн ашиг сонирхлоо хамгаалуулах үүнийгээ мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх гол салбар эрх зүй юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулах зүйл бусдын гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцаа байна.³ Иргэний хэрэг шийдвэрлэх явцад шүүх, шүүгч, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, иргэдийн төлөөлөгч, прокурор гэх мэт тус бүрдээ харилцан адилгүй эрх үүрэг бүхий субъект оролцох бөгөөд тэдгээрийн хооронд тодорхой төрлийн харилцаа зайлшгүй үүсдэг. Эдгээр харилцаа нь бүхэлдээ ИХШХШ эрх зүйн харилцаа болдог. Иргэний хэрэг нь юуны өмнө маргаж байгаа буюу зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар өргөдөл гаргасан иргэн, хуулийн этгээд нөгөө талаас шүүхийн хооронд үүсдэг анхдагч харилцаа юм. Харин иргэний хэрэг гэдэгт тодорхойлохдоо эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэн иргэн, хуулийн этгээд эрхээ хамгаалуулахаар ИХШХШтХ-д заасан журмын дагуу шүүхэд гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг үндэслэл болгон шүүгч захирамж гаргаж үүсгэсэн хэрэг гэж ойлгож болно.⁴

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрүү болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгарах гол онцлог бол диспозитив зарчим

¹ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 26 дахь тал

² Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 17 дахь тал

³ Жадамбын Наранцацрал, Авирмэдийн Дугармаа, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: ВСИ, хэвлэлийн газар, 2007) 28 дахь тал

⁴Т.Мөнхжаргал, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги*, (Улаанбаатар: 2008 он)

үйлчлэх явдал юм. Энэ зарчим нь талууд иргэний процессын эзэн байна гэсэн агуулгатай бөгөөд Монгол улсын Үндсэн Хууль болон Иргэний хуульд тусгасан хувийн чөлөөт байдлын зарчим, гэрээ байгуулах эрх чөлөөний процессын эрх зүйн хувилбар хэмээн тооцдог. Агуулгын хувьд ИХШХША-г эхлүүлэх, дуусгавар болгох асуудал зөвхөн талуудын гарт байх ба өөр хэн ч энэ талаар шийдэж үл болно.⁵

Иргэний процесс нь гагцхүү холбогдох этгээдийн гомдол, хүсэлт, нэхэмжлэлийн үндсэн дээр эхэлнэ. ИХШХША-нд талууд процесс эхлэх, хэрхэн үргэлжлэх дуусгавар болох эсэх асуудлыг бие даан шийддэг диспозитив зарчим үйлчлэх тул маргааны үндэс суурь болсон нөхцөл байдлыг өөрсдөө шүүхэд толилуулах үүрэгтэй байдаг. Үндсэндээ талууд шүүгчид нөхцөл байдлыг мэдүүлж, шүүгч үүнд эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгдөг гэж хэлж болно. Ийнхүү мэдүүлэх үйл явц нь нотлох баримт хуваарилах зарчмын дагуу мэтгэлцээний аргаар явагддаг. Тиймээс диспозитив аргаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг аль ч процессын салбарт мэтгэлцэх зарчим үйлчлэх нь зайлшгүй бөгөөд эдгээр нь Монгол улсын Үндсэн хуулиар хамгаалсан хувь хүний чөлөөт байдлын зарчмын процессын эрх зүй дэх тусгал болдог. Мэтгэлцэх зарчмыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим байхаар тусгаж өгчээ.

Мэтгэлцэх зарчим нь диспозитив зарчмын нэгэн адил хувийн чөлөөт байдлын нэг илрэл бөгөөд эсрэг утга бүхий ухагдахуун нь мөрдөн шалгах зарчим байдаг. Мөрдөн шалгах зарчим үйлчилж буй нөхцөлд тухайлбал эрүүгийн процесст шүүх өөрөө шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг судалж, тогтооно. Харин мэтгэлцэх зарчим үйлчлэх бол талууд маргааны зүйл болсон үйл явдлыг аль болох бүрэн бүтэн, үнэн зөвөөр толилуулах үүрэгтэй. Энэ үүргээ амаар мэдүүлэх эсвэл бичгээр тайлбарлах замаар биелүүлнэ. Ингээд шүүх сонсож, танилцсан бодит баримт материалыг үндэслэн шийдвэр гаргадаг. Ердийн тохиолдолд иргэний хэрэг шийдвэрлэж буй шүүх сайн дураараа хэргийг мөрдөхгүй. Хэрэв нэхэмжлэгч хүсээд байгаа шаардах эрхийг гэрчлэхүйц үйл явдлыг толилуулж эс чадвал нэхэмжлэлийг үндэслэлгүй хэмээн хэрэгсэхгүй болгох ба нэхэмжлэгч шүүхэд мэдүүлээгүй ч өөр бусад баримт сэлтээр эрхийг нотлох боломжтой эсэхийг шалгах эрх хэмжээ иргэний хэрэг шийдэж буй шүүхэд байхгүй. Түүнчлэн мэтгэлцэх зарчмын агуулгаас аливаа нөхцөл байдлыг нотлох

⁵ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 21 дэх тал

баримтаар гэрчлэх шаардлагатай эсэхийг талууд өөрсдөө тодорхойлох эрхтэй байдаг.⁶ Материаллаг үнэнийг тогтооход нийтийн ашиг сонирхол бий гэж үзвэл мэтгэлцэх бус, харин мөрдөн шалгах зарчим давуу үйлчилдэг талтай. Зарим гэр бүлийн болон хүүхдийн асуудлаарх маргаанд эдгээр зарчим холилдон үйлчлэх шаардлага гардаг. Харин нотлох ажиллагааны явцад мэтгэлцэх зарчим хязгаарлагдана. Гэрчийн мэдүүлгийн хувьд мэтгэлцэх зарчим бүрэн үйлчилж, талуудын хүсэлтийн үндсэн дээр л гэрчийг асууна. Харин үзлэг, туршилт (ИХШХШТХ-ийн §48.1), шинжээчийн дүгнэлт гаргуулах (ИХШХШТХ-ийн §47.1), хэргийн материал бүрдүүлэх, тэмдэглэл үйлдэх (ИХШХШТХ-ийн §51), зохигчоос мэдүүлэг авах (ИХШХШТХ-ийн §42.1) болон бусад байгууллагаас баримт бичиг гаргуулах (ИХШХШТХ-ийн §44.4) шийдвэрийг шүүх гаргах эрхтэй байна.⁷

1.1.1. Нотолгооны үе шат, шүүхийн нотолгооны тухай ойлголт

Шүүх материаллаг эрх зүйн хэм хэмжээний урьдчилсан нөхцөлүүд амьдралын тодорхой тохиолдолд хэрэгжсэн эсэхийг нягталдаг. Үйл баримтыг тухайн хэрэглэвэл зохих хэм хэмжээтэй нийцэж буй эсэхийг харьцуулан дүгнэх ажиллагааг орчин үед субсумци гэсэн нэр томъёогоор тэмдэглэх ба энэхүү үйлдэл нь шүүхийн шийдвэрийн үндэс болно. Нотолгооны онол эрх зүй нь нэгдүгээрт бодит байдал дээр маргааны цөм болсон үйл явц хэрхэн өрнөснийг тогтоох, хоёрдугаарт шүүх ямар үйл баримтыг шийдвэрийнхээ үндэс болгохыг тодорхойлох гэсэн үндсэн чиг үүрэгтэй байдаг.⁸ Иргэний хэргийг үнэн зөв шийдвэрлэх үндсэн нөхцөл нь тухайн маргаантай холбоотой нөхцөл байдлууд буюу бодит үнэнийг нотолгооны хэрэгслүүдээр магадлан тогтоох бөгөөд иргэний хэргийн зохигчид оролцогчдын шаардлага, татгалзлын үндэслэл болсон баримт, сэлт түүнчлэн иргэний хэргийг үнэн зөв бодитойгоор шийдвэрлэх ач холбогдол бүхий бусад нөхцөл байдлуудыг тогтоох зорилгоор нотолгооны зүйлсүүдийг тодорхойлох, нотолгооны хэрэгслийг цуглуулах, гаргуулж авах, нотлох баримтуудыг үнэлэх талаар иргэний хэргийн оролцогчид болон шүүхээс ИХШХШТХ-д заасан үндэслэл журмаар гүйцэтгэж байгаа үйл ажиллагаануудыг шүүхийн нотолгоо гэж хэлж болно.⁹

⁶ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 23 дахь тал

⁷ Мөн тэнд, 27 дахь тал

⁸ Мөн тэнд, 99 дэх тал

⁹ Т.Мөнхжаргал, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги*, (Улаанбаатар: 2008 он)

Маргааны үйл баримтын талаарх мэдээлэл бүхий нотлох баримтыг нэхэмжлэл болон хариу тайлбарт тусгагдсанаар эхэлж, шүүхэд нотлох баримтыг гаргаж өгөх, цуглуулах, нотлох баримтыг бүрдүүлэх, шинжлэн судлах, үнэлэх гэсэн үе шаттайгаар хэрэгждэг ба үүнийг нотлогооны үе шат гэж нэрлэдэг. ИХШХША-нд ач холбогдол бүхий үйл баримтыг шүүхэд толилуулах, тэдгээрийг нотлох үүргийг зохигч талууд хүлээдэг¹⁰. Энэ үүрэг нь мэтгэлцэх зарчмын шууд илрэл боловч бүх зүйлийг нотлоод байх шаардлагагүй; гагцхүү аливаа үйл баримт нь тухайн маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой, аль хэдийн нотлогдсон гэж үзэхээргүй нөхцөл байдал, эсрэг тал үйл баримтыг хангалттай эсэргүүцсэн буюу маргаантай нөхцөлд нотлох шаардлагатай байж нотлох баримт гаргах шаардлага бий гэж үзнэ.¹¹

1.1.2. Нотлох ажиллагаа ба нотолгооны хэрэгсэл

Шүүх тодорхой үйл явдал болсныг нотлох шаардлагатай гэж үзвэл нотлох ажиллагааг эхлүүлнэ. Шүүх болон зохигч нь нотлох ажиллагааг хэрхэн хийж гүйцэтгэх ёстойгоос шалтгаалан хуульд заасан аргаар "хатуу" нотлох баримт гаргах ажиллагааг чөлөөт нотолгооноос ялгаж үздэг. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд албан ёсоор нотлох ажиллагааг ИХШХШТХ-д тусгайлан зохицуулсан байх ба 37 дугаар зүйлээс 51 дүгээр зүйлүүдэд тусгасан байдаг. Иргэний хэрэгт нотлох баримтыг хуульд заасан хэлбэрээр цуглуулахыг "хатуу" буюу процессын дагуу явагдах ажиллагаа гэж үзнэ. Нотлох үүрэг хуваарилагдсан талд хуульд заасан 5 нотлогооны хэрэгслийг ашиглан нотолгоог гаргах боломжтой. Эдгээрийг тус тусад нь хуулчилсны дээр энд шүүгчийн нотлох үйл ажиллагаатай холбоотой ерөнхий зохицуулалт мөн үйлчилнэ. Нотлох ажиллагаа нь дараах 5 үндсэн төрөлтэй. Үүнд:

- Зохигчоос тайлбар авах ажиллагаа, ИХШХШТХ-ийн 42 дугаар зүйл
- Гэрчийн мэдүүлэг авах ажиллагаа ИХШХШТХ-ийн 43 дугаар зүйл
- Бичмэл нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа, ИХШХШТХ-ийн 44 дүгээр зүйл
- Эд мөрийн баримт бүрдүүлэх ажиллагаа, ИХШХШТХ-ийн 45 дугаар зүйл
- Шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагаа, ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйл

Онцгой нөхцөлд шүүх үйл баримтыг тогтоохдоо эдгээр хуульд заасан нотолгооны хэрэгсэл болон нотлох ажиллагаагаар хязгаарлагдалгүй чөлөөт нотолгоог ашиглах

¹⁰ Жадамбын Наранцацрал, Авирмэдийн Дугармаа, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: ВСИ, хэвлэлийн газар, 2007) 87 дахь тал

¹¹ Мөн тэнд

боломжтой ч энэ асуудал нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Тухайлбал шүүгч эрх хэмжээнийхээ хүрээнд тодорхой албан байгууллагаас лавлага авах эсвэл утсаар мэдээлэл авах тохиолдол ИХШХША-нд элбэг тохиодог.

Нотолгоо нь шүүхийн нотолгоо, нотолгооны зүйл буюу нотлогдвол зохих зүйл, нотолгооны хэрэгсэл, нотлох баримт гэсэн ойлголтууд үйлчилдэг. Иргэний хэргийн нотлох баримт нь нотолгооны хэрэгслээр тогтоогдох бөгөөд үүнд хэргийн оролцогчдын тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, кино ба гэрэл зураг, дүрс дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв. үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг хамаардаг байна.

Нотолгооны хэрэгсэл бол нотлох баримт биш бөгөөд нотлогдвол зохих зүйл буюу нотолгооны зүйлийг тогтоосон эсхүл үгүйсгэж буй ИХШХШТХ-ийн болон бусад хууль тогтоомжид заасан үйл баримтууд болно. Нотолгооны хэрэгслийг ашиглан нотолгооны зүйлийг тодорхойлдог. Нотолгооны хэрэгсэл олон төрөл байх нь маргаантай асуудлыг бодитой үнэн зөв шийдвэрлэх эрэлт шаардлага, тухайн үеийн шинжлэх ухаан, техникийн боломжийг хэр зэрэг өргөнөөр ашиглаж байна вэ? гэдэг түвшинтэй холбоотой. Иргэний хэрэг ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2-т нотолгооны хэрэгслийн тухай дурдсан. Шүүн таслах үйл ажиллагаанд шинжлэх ухаан техникийн ололтыг өргөнөөр хэрэглэх болсон өнөө үед хуульд дурдсан нотолгооны эдгээр хэрэгслээс гадна бүх төрлийн үнэр, хүний үсний бүтэц, ердийн хөсгийн ба тээврийн хэрэгслэлийн мөрний шинжүүдээр нотолгооны зүйлсүүдийг тогтоодог журамтай байхыг үгүйсгэж болохгүй. Нотолгооны хэрэгсэл хэдий чинээ олон хэлбэр төрөлтэй байна, төдий хэмжээгээр эрх зүйн маргааныг бодитой шийдвэрлэх бололцоо, магадлал өндөр байдаг байна¹².

1.2. Шинжээчийн дүгнэлт нотолгооны хэрэгсэл болох нь

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжлэх ухаан техник, урлаг судлал зэрэг тусгай мэдлэгийн үнэлэлт шаардагдах асуудлаар шинжээч томилж, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай болдог. Орчин үед техникийн ухаан, шүүх эмнэлэг, шүүх сэтгэц гэм судлал, нягтлан бодох бүртгэл, мал эмнэлэг, геологи, криминалистик зэрэг шинжлэх ухааны салбаруудаар шинжээч томилж дүгнэлт гаргуулдаг болсон. Хуульд зааснаар шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг хэрэг хянан шийдвэрлэх

¹² Т.Мөнхжаргал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, (Улаанбаатар: 2008)

явцад тодруулахын тулд шинжээчийг томилно¹³. ИХШХША-ны явцад тусгай мэдлэг шаардагдах асуудлаар тодруулга хийх шаардлагатай нөхцөлд шүүхээс томилогдсон эрх бүхий мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, мэргэшсэн ажилтны бичгээр гаргаж буй үнэлэмжийг шинжээчийн дүгнэлт гэж ойлгох¹⁴ ба ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1, Шүүх шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-т зааснаар ойлгоно .

ИХШХШТ хуулийн 47 дугаар зүйлд: Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн санаачилгаар шүүгч захирамж гарган шинжээчийг томилно¹⁵.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлд: "Шинжээчийн дүгнэлт" гэж хуульд заасан шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангаж, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг хэлнэ¹⁶. Хэмээн тус тус хуульчилжээ.

Харин эрх зүйн толь бичигт шинжээчийн дүгнэлтийг "шүүхийн шинжилгээ" гэсэн утгаар тайлбарласан байх ба шинжилгээ гэдэг нь тусгай мэргэжил эзэмшсэн этгээдээс шинжлэх ухааны тодорхой салбарын онол, арга зүйг хэрэглэн бодит материал дээр судалгаа хийх зорилгоор хуульд заасан журмын дагуу үйл ажиллагаа явуулж, тодорхой асуудалд шинжлэх ухааны үндэстэй хариулт өгөх явдал¹⁷ байна. Шинжилгээг дотор нь:

- Анхны шинжилгээ
- Нэмэлт шинжилгээ:
- Шинжээчийн анхны дүгнэлт тодорхойгүй буюу бүрэн биш болсон тохиолдолд түүнийг нөхөн гүйцэлдүүлж, дүнг бүрэн гаргах зорилгоор нэмэлт шинжилгээ хийгддэг.
- Дахин шинжилгээ:
Өмнөх шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй буюу зөв болох нь эргэлзээтэй байгаа тохиолдолд тухайн асуудлаар давтаж хийгддэг шинжилгээг дахин

¹³ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 144 дахь тал

¹⁴ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 119 дэх тал

¹⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2008)-ийн 47 дугаар зүйлийн 47.1

¹⁶ Шүүх шинжилгээний тухай хууль (2022)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8

¹⁷ Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт*, 2008 он.

шинжилгээ гэдэг. Энэ тохиолдолд анхны шинжилгээ хийсэн шинжээчийг дахин шинжилгээ хийх бүрэлдэхүүнд оролцуулдаггүй.

- Комиссын шинжилгээ:

Комиссын буюу бүрэлдэхүүнтэй шинжилгээг нэг төрлийн мэргэжлийн гурваас дээш шинжээч явуулдаг.

- Иж бүрэн шинжилгээ:

Иж бүрэн шинжилгээ явуулахад хэд хэдэн төрлийн мэргэжлийн шинжээчид оролцож, дүгнэлт гаргадаг¹⁸.

Хуульд заасан "тусгай мэдлэг" гэдэг нь шүүгч эзэмшээгүй, хуульчийн эзэмшсэн мэргэжил мэдлэгээс өөр мэдлэг чадварыг хэлнэ. Шүүгч уг асуудлаар тусгай мэдлэг эзэмшсэн, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай бол шинжээч томилох шаардлагагүй.

Шинжээчийн үнэлэмж нь үйл баримтыг тогтоох ба нөхцөл байдал, үйл явдлын өрнөлд дүгнэлт өгсөн шинжтэй байна. Шинжээч нь ИХШХША-нд шүүхэд туслах, зөвлөх чиг үүрэгтэй оролцож байгаа ч шийдвэр гаргагч бус, нотолгооны эх сурвалж, хэрэгсэл бөгөөд шүүгч шинжээчид заавар өгөх эрхтэй. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд зөвхөн хэргийн оролцогч буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн шүүгч захирамж, шүүх тогтоол гарган шинжээчийг томилно. Шүүх татгалзах үндэслэлгүй бол хүсэлтийг хангаж, захирамж, шүүхийн тогтоол гарган шинжээч томилсон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Ингэхдээ мөн хуулийн 71 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацаатай шинжилгээ хийх хугацааг уялдуулан тогтоодог¹⁹ ба хугацаа тогтоох нь хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийн эрх хэмжээний асуудал байна.

Шүүх шинжээч томилохдоо хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэх ба уг хүсэлтийн агуулга зөв, хоёрдмол утгагүй шинжээчээс яг юуг тодруулахыг хүссэнээ тодорхой оруулсан ба шинжээчийг зөвхөн хүсэлтийг хангаж шинжээч томилох эсэхийг шүүх шийдэх бөгөөд хангасан тохиолдолд энэ тухай шүүгчийн захирамж гарна. Иймд зохигч өөрийн дур зоргын дагуу шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан

¹⁸ Мөн тэнд

¹⁹ Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал*, 2014 он

оролцуулах эрхгүй. Шинжээчийг зөвхөн зохигчийн хүсэлтээр томилох асуудал нь зохигчийн өөрийн шаардлага, татгалзлыг шүүхэд өөрөө нотлох тухай ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2., 38 дугаар зүйлийн 38.1.-д заасан үүрэгтэй шууд холбоотой юм. Гэтэл шинжээчийн дүгнэлт нь зөвхөн нотолгооны хэрэгсэл, нотлох баримт байхаас гадна нотлох баримтыг үнэлэх шүүхийн ажиллагаанд чухал ач холбогдолтой хэрэгсэл болдог. Тухайлбал, бичмэл нотлох баримтыг үнэн зөв эргэлзээгүй талаас нь үнэлэхийн тулд уг баримтад зурагдсан гарын үсэг тухайн этгээдийн гарын үсэг мөн эсэхийг бүрэн тогтоох шаардлагатай байдаг²⁰. Үүнээс гадна шүүхээс томилогдсон шинжээч дүгнэлтээ дутуу, эсхүл эргэлзээтэй гаргасан тохиолдолд шүүх нэмэлт, эсхүл дахин шинжилгээ хийлгэх шаардлагатай болдог. Гэтэл зохигчид энэ талаар хүсэлт гаргахгүй бол шүүх шинжээчийн дутуу дүгнэлтэд шийдвэрээ үндэслэх боломжгүй юм. Т.Мөнхжаргал багшийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги, 2008 он” сурах бичигт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүгч захирамж, шүүх тогтоол гарган шинжээчийг томилно. Шүүх өөрийн санаачилгаар шинжээч томилохыг хориглоно”²¹ хэмээн тусгажээ. ИХШХШТХ-ийн 111 дүгээр зүйлийн 111.3.-т шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус буюу үндэслэлгүй, эсхүл шинжээч зөрүүтэй дүгнэлт гаргасан бол өөр шинжээчээр дахин шинжилгээ хийлгэх эрхийг шүүхэд олгосон боловч энэ хуулийн 47 дугаар зүйлд шинжээчийг зөвхөн зохигчдын хүсэлтээр томилох зохицуулалттай зөрчилдөж байсан зөрүүг хууль тогтоогч 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар залруулж, дахин эсхүл нэмэлт шинжээч томилох хуульд заасан тохиолдолд шүүх дан ганц зохигчдын хүсэлтийг харах шаардлагагүй болсон байна²². Шинжээч томилсон шүүхийн ажиллагаа нь ШШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 болон 17 дугаар зүйлийн 17.1 болон 17.4-т заасантай нийцсэн байна.

Хуульд заасны дагуу шинжээчийг томилж буй албан тушаалтан шинжилгээ хийлгэх хугацааг тогтоож өгөх ба шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектийн тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг

²⁰ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 145 дахь тал

²¹ Т.Мөнхжаргал, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги* (Улаанбаатар: 2008), 71 дэх тал

²² Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 145 дахь тал

тогтоох бөгөөд заасан хугацаанд дүгнэлт гаргах боломжгүй бол шинжилгээ хийх хугацааг сунгуулах хүсэлтээ шинжилгээ хийх эрх бүхий этгээдэд гаргана²³.

1.2.1. Шинжээчид тавигдах шаардлага, түүнийг сонгох ажиллагаа

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4.-т "мэргэшил" гэсэн шинжээчид тавигдах гол шаардлага нь тодорхой асуудлаар мэргэшсэн байх явдал мэдлэг, чадварын түвшин"²⁴ гэж тодорхойлсон байх ба шинжээчийн бие хүнд тавигдах шаардлага нь тусгай мэдлэгийг эзэмшсэн байх явдал байна.

Шинжээчээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийг томилж болно. Мөн тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж, мэргэшсэн уг асуудлаар шинжилгээ хийж дүгнэлт гаргах чадвар бүхий хувь этгээд байж болно. Шинжээч нь уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байх ба ШШТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу шинжилгээ хийх эрх авсан шинжээч²⁵ байна.

Жишээ нь: Татварын төлбөр тооцоотой холбоотой маргаанд холбогдох асуудлаар шинжээч томилохдоо татвар төлөгчийн дотно найз, нөхдийн болон төрөл, садангийн холбоотой эсхүл хамтарч ажилладаг этгээдийг томилбол тэр нь хувийн сонирхол бүхий этгээд болно. Тэгвэл энд Татварын ерөнхий газар, Сангийн яам, тэдгээрийн албан тушаалтнуудыг шинжээчээр томилбол албаны сонирхолтой этгээдэд хамаарч болох юм. Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийг шинжээчээр томилсон тохиолдолд тухайн байгууллага өөрийн шинжээчийг томилно. Байгууллага нь нэг буюу хэд хэдэн шинжээчийг томилж болно. Энэ шинжээч нь байгууллагын нэрийн өмнөөс дүгнэлт гаргах ба шинжээчийн дүгнэлтийн үнэн зөвийг тухайн байгууллага хариуцах учиртай. Шинжээчээр хувь этгээд томилогдсон бол өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах ба шинжилгээ, дүгнэлтийнхээ үнэн зөвийг өөрөө хариуцна²⁶. Шинжээчээр ХАҮТ, улсын комисс, нийгмийн халамжийн байгууллага зэрэг байгуулсан гэрээний үндсэн хэргийн материалаас ямар нотлох баримтыг эхээр, эсхүл хуулбараар шинжээчид хүргүүлж байгааг дагалдах албан бичигт тодорхой бичих шаардлагатай.²⁷ Шинжээчийн гол

²³ Тогоохүүгийн Очирбат, *Шүүх шинжээчийн хөтөч*, (Улаанбаатар: 2013), 10 дахь тал

²⁴ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 120 дахь тал

²⁵ Шүүх шинжилгээний тухай хууль (2022)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Тусгай мэдлэг бүхий хүнд..... хугацаагаар олгоно”

²⁶ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 146 дахь тал

²⁷ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он), 120 дахь тал

зорилго бол эрх бүхий байгууллагын тавьсан асуултад өөрийн мэргэжлийн ур чадвар, мэргэжил, мэргэшлийг ашиглан хариулт өгөхийг хэлнэ. Иймд шүүхээс асуулт тавиагүй байхад дүгнэлт гаргасан эсхүл шүүхийн тавьсан асуултад хариулаагүй бол шинжээчийн дүгнэлтийг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт нийцсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй болно²⁸.

Шинжээчийн хариуцлага:

Шинжээчийн дүгнэлт алдаатай, худал тохиолдолд эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх ба энэ тухай эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд хуулчилсан байна.

Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т²⁹ “Шинжээч шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд, эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд үнэн зөв дүгнэлт гаргахаа илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал дүгнэлт гаргасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ³⁰ хэмээн заажээ. Энэхүү заалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадна иргэн болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч шууд хамаарах хариуцлагын тухай заалт юм. Шинжээч санаатайгаар худал дүгнэлт гаргасан нь нотлогдвол энэ нь Эрүүгийн хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцогддог байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15-т зааснаар “1.Шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, хохирогч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно³¹.”

Мөн 15 дугаар зүйлийн 15.33-т заасан Парламентыг үл хүндэтгэх зөрчилд шинжээч хугацаандаа дүгнэлт гаргаж өгөөгүй эсхүл мэдүүлэг өгөхөөс зайлсхийх³² тохиолдолд хүнийг гурван зууг нэгжтэй тэмцэх хэмжээгээр торгох шийтгэлийг тус, тус заажээ.

²⁸ Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал*, 2014 он

²⁹ Эрүүгийн хууль (2015)-ийн 21 дүгээр зүйлийн 21.4

³⁰ Мөн тэнд

³¹ Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 15 дугаар зүйлийн 15.15

³² ЗтХ(2017)-ийн 15 дугаар зүйлийн 15.33

Шинжээчил эрх олгох, эрхийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг нь ШШТХ-ийн 11 дүгээр зүйлд хуульчлагдсан байх ба уг асуудлыг тусгай журмаар зохицуулдаг бөгөөд энэхүү эрх нь зөвлөлийн үйл ажиллагаанд хамаарна³³. Уг зөвлөл нь шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтад заасан шинжилгээний төрөлд хамаарах салбарын төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон эрдэмтдийн төлөөлөл, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон шүүх шинжилгээний байгууллагын төлөөллөөс бүрддэг³⁴ байна.

1.2.2. Иргэний хэрэгт шинжээч томилох маргааны төрлүүд³⁵

Хүснэгт 1. 1. Шинжээч томилох маргааны төрлүүд

Маргааны төрөл	Үнэлэх онцлог
Гэр бүлийн маргаан	Хүүхдийн эцэг тогтоолгох маргаанд хийгдэж буй шинжээчийн дүгнэлтийг ямар шинжилгээгээр гаргасныг анхаарах хэрэгтэй бөгөөд ДНК-ийн шинжилгээний магадлал 98 хувь байдаг тул эцэг мөн биш дүгнэлтийг үнэн зөв гэж үзэх нь үндэслэлтэй. Харин цусны бүлэг болон бүтцээр хийгдсэн шинжилгээний дунд эцэг мөн байх боломжтой гарсан дүгнэлт бусад нотлох баримтаар давхар нотлогдох зайлшгүй шаардлагатай. Харин биш гэсэн дүгнэлтийг шууд нотлох баримт гэж үзэх боломжтой байна ³⁶ .
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн эрх зүйн маргаанд тусгайлан шинжээч томилох шаардлага төдийлэн гардаггүй ч криминалистикийн болон санхүү, нягтлан бодох, тооцоо бүртгэлийн асуудлаар шинжээч томилогдох тохиолдлууд гардаг байна ³⁷ .
Гэм хор учруулснаас үүсэх үүргийн маргаан	Авто осол, үйлдвэрлэлийн осол зэрэг үйл баримт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийгдсэн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон хэдий ч зөвхөн шүүхийн хүчин төгөлдөр тогтоол гарсан тохиолдолд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин нотлогдохгүйгээр уг дүгнэлт нотолгооны хэрэгсэл болдог ³⁸ .
Өв залгамжлалын маргаан	Нас барсан хүний гарын үсэг, бичгийн хэвд криминалистикийн шинжилгээ хийлгэхэд загвар бичилт хангалттай байх, эдгээр бичилтийг нас барсан этгээд өөрөө хийсэн гэдгийг давхар шалгах шаардлагатай ³⁹ .

³³ ШШТХ(2022)-ийн 11 дүгээр зүйлийн 11.12.2

³⁴Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журам, 1.2 дахь хэсэг

³⁵ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 146 дахь тал

³⁶ Мөн тэнд

³⁷ Мөн тэнд

³⁸ Мөн тэнд

³⁹ Мөн тэнд

Зарим төрлийн шинжилгээний тухайд⁴⁰:

Хүснэгт 1. 2. Шинжилгээг хийлгэх шаардлага

Шинжилгээний төрөл	Шаардлага	Шинжилгээ хийх байгууллага
Хөрөнгийн үнэлгээ тогтоох	Шүүх шинжээч томилох замаар хөрөнгийн үнэлгээ тогтоох боломжтой.	Үнэлгээчин үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрээний үндсэн дээр хөрөнгийг үнэлэхээс гадна эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэлгээ хийх талаар Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заажээ ⁴¹ .
Хүүхдийн асрамж, тэтгэмж тогтоох хэргийг шийдвэрлэхэд хийгдэж байгаа шинжилгээ	Шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ эцэг, эхийн хүмүүжил, халамж, амьдралын нөхцөл бололцоог харгалзахын зэрэгцээ хүүхдэд дарамт, шахалт үзүүлж байсан эсэхийг хянаж, хүүхдийн сурч боловсрох, эрүүл, аюулгүй орчинд өсөх шаардлагыг илүү хангаж чадах тал зэргийг харгалзан үзнэ.	Боловсролын тухай хуульд зааснаар боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд нь туслах, сургуулийн нийгмийн ажилтан нь суралцагч, эцэг эхийн нийгмийн асуудлаар үнэлгээ хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх үүргийг тус тус хэрэгжүүлдэг тул шүүх шинжээчээр эдгээр байгууллагыг томилох нь хуульд нийцдэг ⁴² .
Зам тээврийн осол, хэргийн улмаас учирсан хохирол нэхэмжилсэн хэрэгт хийгдэж байгаа шинжилгээ	Осол, хэргийн улмаас бусдад гэм хор учруулсан этгээд түүнийг хариуцан арилгах үүрэгтэй тул хэрэг хянан шийдвэрлэхэд хариуцагчийн гэм бурууг тогтоох нь чухал бөгөөд зохигчид өөрийн гэм буруугүйг нотолж хариуцлагаас чөлөөлөгдөх зорилгоор шинжээч томилуулах хүсэлт гаргадаг.	Зам тээврийн осол, хэрэг гарсан үед ихэвчлэн Цагдаагийн байгууллага хэргийн ул мөр болон ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор үзлэг хийж акт тогтоодог. Энэхүү акт шүүхээс томилогдсон шинжээчийн дүгнэлтэд тооцогдохгүй тул

⁴⁰ Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал*, 2014 он

⁴¹ Мөн тэнд

⁴² Мөн тэнд

		шүүх уг актыг бичмэл нотлох баримтын хэмжээнд үнэлэх ба шүүхээс мэргэжлийн шинжээчийг заавал томилно ⁴³ .
--	--	--

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т "хөрөнгийн үнэлгээ хийх" гэж тодорхой зорилгод нийцүүлэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтоох хараат бус үйл ажиллагааг” хэлнэ хэмээн тусгажээ⁴⁴. Хөрөнгийн үнэлгээний зүйл нь тодорхой үнэ цэнээр үнэлэгдэх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн өмчлөх эрх байх бөгөөд иргэн, хуулийн этгээд нь нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах бөгөөд үүний нэг нь хөрөнгийн үнэлгээ хийх ажиллагаа юм. Иймд тусгай зөвшөөрөлгүй этгээдийг шинжээчээр томилж хөрөнгийн үнэлгээний талаар дүгнэлт гаргуулах нь хуульд нийцэхгүй⁴⁵. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр хөрөнгийг үнэлнэ”⁴⁶ хэмээн заасанд шүүх байгууллага хамаардаг байна.

Хүснэгт 1. 3. Үнэлгээ тогтоолгох маргааны зарим төрөл

Үнэлгээ тогтоолгох маргааны зарим төрөл	Зорилго, жишээ:
Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан	Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дугаар зүйл ⁴⁷ Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулах зорилгоор шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл оролцогч талын хүсэлтээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн ашиг сонирхолгүй этгээдийг шинжээчээр томилон оролцуулж болно.
Гэр бүлийн дундын өмчийн маргаан	Гэрлэлт цуцлах үед хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах шаардлага гардаг. Гэр бүлийн гишүүд орон сууц, автомашин,

⁴³ Мөн тэнд

⁴⁴ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2022)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.14

⁴⁵ Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал*, 2014 он

⁴⁶ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2022)-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3

⁴⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль(2017)-ийн 55 дугаар зүйлийн 55.1

	зуслангийн байшингаа хэн нь авах, нөгөө талдаа хэдэн төгрөгийн нөхөн олговор өгөхийг шийдэх шаардлагатай болно.
Гэм хор учруулснаас үүсэх хариуцлагын маргаан	Авто ослын улмаас автомашинд учирсан эвдрэлийн зардал, эсвэл дээд давхраас ус алдсанаас болж орон сууцанд учирсан хохирлын хэмжээг тогтоох мөн хөрөнгийг анхны байдалд нь оруулахад шаардагдах засвар үйлчилгээний зардал болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцох зэрэг
Өв залгамжлалын маргаан	Өвлөгдөх хөрөнгийн нийт үнийг тогтоож, бусад өвлөгч нарт олгох мөнгөн хувийг тодорхойлох.
Компанийн эрх зүйн маргаан	Хувьцаа эзэмшигч компаниас гарах, эсвэл компани татан буугдах үед компанийн гишүүн өөрт ногдох хувьцаагаа зах зээлийн үнээр засаж авахаар шаардах.

1.2.3. Шинжээчийн дүгнэлтийн бүрдэл, тавигдах шаардлага

Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргах ба шинжээчийн дүгнэлтэд дараах зүйлүүд тусгагдана. Үүнд:

- А. Ямар баримт материалуудыг судалж шинжилсэн тухай тусгана.
- Б. Ямар шинжилгээ хийсэн, шинжилгээ хийсэн арга, хэлбэрийг тодорхойлно.
- В. Тэдгээрт үндэслэн гарсан дүгнэлтийн агуулгыг тодорхой бичнэ. Мөн шинжээчийн дүгнэлтэд шүүгчээс ямар асуулт тавьсан, уг асуултад ямар хариу өгсөн, түүний үндэслэлийг дэлгэрэнгүй тусгасан байх шаардлагатай⁴⁸.

Шинжээчийн дүгнэлтийн агуулга нь дараах гурван хэсгээс бүрдэнэ.

Оршил хэсэг: Дүгнэлт гаргасан байгууллага, хуулийн этгээд, шинжээчийн нэр, үйл ажиллагааны чиглэл, мэргэшлийн байдал, дүгнэлт гаргасан огноо, газрын нэр, шинжилгээ явуулах болсон шүүгчийн захирамжийн огноо, дугаар, шүүхээс ирүүлсэн үндсэн болон нэмэгдэл материал, туршилтын загвар, нэмэлт шинжилгээ явуулж байгаа бол шинжилгээ хийх болсон шалтгаан, шинжээчийн дүгнэлт гаргуулахаар тавигдсан асуулт зэргийг бичнэ.

Шинжилгээний хэсэг: Энэ хэсэгт шинжилгээний объектын талаар болон шинжилгээ хийсэн явц байдлыг тодорхойлно. Мөн шинжилгээ явуулсан аргачлал, хэрэглэсэн багаж, хэрэгсэл, бодис, томьёолол, тогтоогдсон үйл баримтад шинжлэх ухааны үндэслэлтэй

⁴⁸ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 147 дахь тал

тайлбарыг өгнө. Дахин шинжилгээний үр дүн урьдах шинжилгээний дүгнэлттэй зөрж байвал учир шалтгааныг заавал тайлбарлан бичнэ.

Дүгнэлтийн хэсэг: Шүүгчийн захирамжаар шинжээчийн өмнө тавигдсан асуулт бүрт хариулт бичнэ. Шинжээчийн дүгнэлтийг бататгасан баримт болон материалуудыг дүгнэлтэд хавсаргах бөгөөд энэ нь дүгнэлтийн бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд гэрэл зураг, гарын үсгийн загвар, тооцоолон бодох программын дүн, зураг, санхүүгийн баримт зэрэг материал байж болно⁴⁹.

ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.10-т зааснаар шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоосон бол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч дүгнэлтэндээ оруулна. Шинжээч нь хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоон дүгнэлтдээ тусгах эрхтэй. Хуульд заасан “хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал” гэдэг нь шинжээч дүгнэлт гаргах явцдаа шүүгчийн тавьсан асуултаас гадна хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдол бүхий зүйлийг шинжлэн тогтоосныг хэлнэ. Ийнхүү олж тогтоосон зүйлээ шүүхээс асуулт тавиагүй байсан ч дүгнэлтдээ оруулах эрхтэй. Шинжээчийн дүгнэлт нь нотолгооны онцгой хэрэгсэл биш бөгөөд нотлох баримтын бусад төрлийн нэгэн адил шүүх хэрэгт цугларсан бусад нотлох баримттай тал бүрээс нь харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлэх ёстой. Иймээс шинжээчийн дүгнэлтийн талаар шүүхийн үнэлгээ, дүгнэлт шийдвэрт бүрэн тусгагдах учиртай. Түүнд шинжээчийн дүгнэлт юунд тулгуурласан, шинжилгээнд ямар баримт гаргаж өгсөн, тэдгээр нь бүрэн судлагдсан эсэх, шүүхээс тавигдсан асуулт, түүнд ямар хариу өгөгдсөн, уг хариу, дүгнэлтийг шүүх хэрхэн үнэлсэн тухай шийдвэрт тодорхой тусгагдах ёстой⁵⁰. Жишээлбэл: Үнэлгээнийг шүүх шинжээчээр томилсон бол захирамж, тогтоолын дагуу шинжилгээний объектод хийсэн үнэлгээ нь шинжээчийн дүгнэлт болно.

Дүгнэлт нь эд зүйлийн үнэ цэнэ, түүнийг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан үндсэн баримт бичиг бөгөөд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд: шинжээчийн нэр, хөрөнгийн үнэлгээ үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл хөрөнгийн үнэлгээний тайлангийн хамрах хүрээ, хязгаарлах нөхцөл, хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан баримт, мэдээлэл, нотолгоо, шинжилгээ, үнэлгээний тооцоолол, түүний

⁴⁹ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (Улаанбаатар: LIAPubl, хэвлэлийн газар, 2021 он) 121 дахь тал

⁵⁰ Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, (Улаанбаатар: Интерпресс, хэвлэлийн компани, 2008), 146 дахь тал

үндэслэл, хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход хэрэглэсэн арга, горим, тэдгээрийн нийцтэй байдал, хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ, хөрөнгийн үнэлгээг хуульд заасан стандарт, аргачлалын дагуу хийсэн талаарх үнэлгээчний мэдэгдэл зэрэг болно⁵¹.

Үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрээний үндсэн дээр хөрөнгийн үнэлгээ хийвэл “үнэлгээний тайлан”, харин эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэлгээ хийвэл “шинжээчийн дүгнэлт” гаргах бөгөөд эдгээр нь хоорондоо ялгаатай байна. Шүүхийн оролцоогүйгээр Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд хүсэлт гаргаж, хөрөнгийн үнэлгээ хийлгэх боломжтой бөгөөд энэ тохиолдолд “үнэлгээний тайлан” гаргадаг. Үнэлгээний тайлан нь шүүхийн тогтоол, захирамжийн дагуу гарсан шинжээчийн дүгнэлт биш тул уг баримтыг хэргийн оролцогчийн гаргасан бичгийн нотлох баримтын хэмжээнд үнэлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 44 дүгээр зүйлийн 44.1-т нийцнэ.⁵²

Үүнээс дүгнэвэл шүүгчийн захирамжаар томилогдсон шинжээчийн тайлан нь нотолгооны хэрэгслийн шинжээчийн дүгнэлтэд багтах бол үйлчлүүлэгч хувиараа хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан нь бичмэл нотлох баримтад хамаарна гэж ойлгож болно.

1.2.4. Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуур

Хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлд⁵³ заасны дагуу хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх ба тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ. Нотлох баримтыг тал бүрээс үнэлнэ гэдэг нь хэргийн оролцогч хэн алины гаргаж буй үндэслэл, баримтыг анхаарах, нотлох баримтыг аль нэг талын байр сууриас биш харин маргааныг таслах хөндлөнгийн байр сууриас судлаж, үнэлэхийг хэлж байгаа болно. Маргааны эцсийн шийдвэрлэлтэд сонирхолгүй байх явдал нь шүүхэд нотлох баримтыг тал бүрээс үнэлэх боломжийг олгодог.

⁵¹ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний процесс дахь нотлогооны эрх зүй*, (Улаанбаатар: LIA Publishing, хэвлэлийн компани, 2024 он), 144 дэх тал

⁵² Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал*, 2014 он,

⁵³ ИХШХШТХ (2002)-ийн 40 дүгээр зүйлийн 40.1

Нөгөө талаар нотлох баримтыг тал бүрээс үнэлнэ гэдэг нь хэрэгт цугларсан нотлох баримтыг бүрэн дүүрэн судалж, үнэлнэ гэсэн үг ба хэрэгт авагдсан нотлох баримт бүрийн талаар шүүх үнэлгээ өгсөн байх шаардлагатай. Энэхүү үнэлгээ нь тухайн нотлох баримтын хамаарал, ач холбогдол, зөвшөөрөгдсөн байдлаас шалтгаалан өөр өөр байх боловч үнэлэгдэхгүй орхигдох ямар ч нотлох баримт байх учиргүй. Хэрэгт цугларсан нотлох баримт маргааныг хянан шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл шүүх нэмэлт баримт гаргуулах талаар зохигчдод санал болгох боломжтой бөгөөд энэ ажиллагааг хууль зөрчсөн гэж үзэхгүй. Нотлох баримтыг үнэлж буй шүүх тухайн баримтыг бусад нотлох баримттай хэрхэн дүйцэж байгаа, тэдгээрийн хооронд ямар уялдаа холбоо байгаа, баримтууд бие биенээ үгүйсгэж байгаа эсэх, нэг үйл баримтыг давхар нотолж байгаа эсэхийг тус тус шалгадаг тул “бодитойгоор харьцуулан үзэх” гэсэн ойлголт нотлох баримтыг тал бүрээс үнэлэх ажиллагааны хэсэг⁵⁴ болдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй ба шүүгч дараах асуултад хариулт эрэх замаар шинжээчийг томилоно. Үүнд дараах асуултауд багтаж байна:

- Шинжээчийн дүгнэлт чухам юуг нотлох зорилготой вэ?
- Хүсэлт нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой эсэх?
- Шинжээчээр ямар этгээдийг томилох эсэх?
- Шинжээчид ямар асуулт тавих эсэх?
- Ямар хугацаанд шинжээчийн дүгнэлтийг гаргуулахаар даалгах эсэх?

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуурыг Монгол улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах байдлаар нэгтгэж үзэх нь тохиромжтой.

- Маргаангүй, эргэлзээгүй үйл баримтыг эхний ээлжинд шинжилгээний үндэс болгох
- Бүрэн бүтэн байдал
- Үнэмшилтэй байдал
- Эх сурвалжаа ил тод болгох, энэ нь ШУ-ны орчин үеийн стандартад нийцсэн эсэх
- Мэргэжлийн ур чавдар, практик туршлага өндөр байх
- Нөлөөлөлд автаагүй байх зэрэг багтана⁵⁵.

⁵⁴ Улсын Дээд Шүүхийн Зөвлөмж, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд нотлох баримт үнэлэх шүүгчийн ажиллагаа*, 2008 он, 3.1 дэх хэсэг

⁵⁵ Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний процесс дахь нотлогооны эрх зүй*, (Улаанбаатар: LIA Publishing, хэвлэлийн компани, 2024 он), 154 дэх тал

Бүлгийн дүгнэлт:

Шинжээчийн дүгнэлт нь ИХШХША-ны тусгай мэдлэг шаардсан үйл баримтыг тогтоох нотолгооны хэрэгсэл юм. Энэ нь шүүгчийн эзэмшээгүй нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвар шаардах хэрэгт ач холбогдолтой нотолгооны зүйлийг тогтооход чиглэсэн ажиллагаа байна. Шинжээчийн дүгнэлт нь нотлох ажиллагааны эх сурвалж болдог боловч бусад нотлох баримтаас давуу эрхтэй гэсэн ойлголт биш. Шүүх шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримттай тал бүрээс нь харьцуулан шинжэлсний үндсэн дээр шийдвэр гаргадаг. ИХШХШТХ-ийн дагуу шинжээчийг зохигчийн хүсэлтээр томилох ба нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа, хариуцагч хариу тайлбараа нотлох үүргийг хүлээнэ. Энэ нь хуульд заасан мэтгэлцэх болон диспозитив зарчимд нийцдэг. Шинжээчийг томилох нь хэргийн оролцогчийн хүсэлтэд үндэслэдэг боловч дүгнэлт эргэлзээтэй эсвэл зөрүүтэй гарсан тохиолдолд шүүх дахин болон нэмэлт шинжилгээ хийлгэх эрхтэй байна. Шинжээч нь тухайн асуудлаар мэргэшсэн, ашиг сонирхлын зөрчилгүй этгээд байх бөгөөд зориуд худал дүгнэлт гаргавал эрүүгийн хуульд заан хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалттай. Зөвхөн шүүгчийн захирамжаар томилогдсон шинжээчийн ирүүлсэн дүгнэлтийг шинжээчийн дүгнэлт гэж үзэх бөгөөд бусад тохиолдолд бичмэл нотлох баримтын хүрээнд үнэлдэг.

II. БҮЛЭГ. ҮНДСЭН СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. Шинжээчийн дүгнэлтийг шүүхээс нотлох баримтаар үнэлэхэд тулгамдсан асуудал

Энэхүү хэсгийн хүрээнд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд 2026 оны 3 дугаар сарын 15-ны Төв аймгийн анхан шатны эрүү, иргэний шүүхийн шүүгч Д.Алтантуул шүүгчтэй ярилцан асуудлыг тодорхойлохыг зорив. (Д.Алтантуул шүүгч болон түүний туслах Б.Оюут нарын удирдлага доор 2024 оны 6 дугаар сард танилцах дадлага хийж гүйцэтгэсэн тул шүүгчээс зөвшөөрөл авч судалгааны оролцогчоор сонгосон болно.)

Хүснэгт 2. 1. *Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь*

Асуулт: Шинжээчийг ямар тохиолдолд томилдог вэ?
Хариулт: “Хэргийн оролцогчдын хүсэлтээр шинжээчийг томилно. Шинжээч томилуулах тал яг ямар бичиг дээр гарын үсгийг шинжлүүлэхээ хэлдэггүй. Зээлийн гэрээ болон мөнгө хүлээн авсан баримт байж, зээлийн гэрээнд зээлдэгч гарын үсэг зурсан байж тухайн гарын үсэг мөн эсэх дээр шинжээч томилуулна. Тиймээс шинжээч томилуулах хүсэлтдээ аль баримт дээр, яг юуг шинжлүүлэхээ тодорхой дурдсан байх шаардлагатай. Шинжээч томилуулах хүсэлтийг хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд хангаж шүүгч захирамж гаргадаг”.
Асуулт: Шинжээч хугацаандаа дүгнэлтээ ирүүлэхгүй байх, дүгнэлт гаргах боломжгүй зэргээс хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол байдаг уу?
Хариулт: “Шинжээч томилох хугацааг шүүхээс тогтоож өгдөг. Хугацаандаа ирүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд тоот явуулдаг. Хугацаа хэтэрсэн ч шинжээчийн дүгнэлт ирэхэд түдгэлзүүлсэн ажиллагааг сэргээж хэргийг үргэлжлүүлэн шийддэг. Шинжээчийн дүгнэлт ирэхгүйтэй холбоотой хэрэг шийдэгдэхгүй байна гэж байхгүй, харин ХХША удааширдаг тохиолдол элбэг байдаг”.
Асуулт: Шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хүрээнд эргэлзээгүй үнэлдэг маргааны төрөл байдаг уу?
Хариулт: “Хамгийн ойрын жишээ бол эцэг тогтоолох шинжилгээ байна. Хариуцагч нь миний хүүхэд биш, тиймээс хүүхдийн тэтгэмж өгөх шаардлагагүй. Үүнийгээ нотлуулахын шинжээч томилж өгнө үү эсвэл нэхэмжлэгч тал хүүхдээ хариуцагчийн хүүхэд мөн учир эцэг тогтоолох шинжилгээ хийлгэж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу шинжээч томидог. Шүүх шинжилгээний байгууллагаас мөн бишийг

<p>тогтоосон шинжээчийн дүгнэлт ирэх ба энэхүү дүгнэлтийг хэрэгт ач холбогдолтой талаас нь эцэг мөн эсвэл биш магадлалын хувьд үнэлэхэд эргэлзээгүй байна”.</p>
<p>Асуулт: Талууд шинжээч томилох талаар мэдэхгүй тохиолдолд яах вэ?, шүүх санаачилгаараа шинжээч томилж болох уу?</p>
<p>Хариулт: “Талууд хүсэлт гаргаж мэдэхгүй бол шүүх хуралдаан дээр тодруулна. Эцэг тогтоолгох дээр аваад үзвэл “Та яагаад биш гэж байгаа вэ? Биш гэдгийг чинь нотлох баримт байна уу? Байхгүй бол шинжилгээний байгууллагаар тогтоолгох боломжтой. Шинжээч томилуулах хүсэлтийг шүүхэд гаргаж болно хэмээн тайлбарлана. Үүнийг мэдсэн учраас шинжээч томилуулах хүсэлтийг шүүхэд өгдөг тохиолдлууд байдаг. Шүүх хэдий санаачилгаараа гэж байгаа боловч хуулийг хүн болгон мэдэхгүй учраас санаачилгаа өгөөд түүнийг нь талууд дэмжих асуудал байна. Нөгөөтэйгүүр баттай мөн бишийг нь нэгэнт шийднэ гэж байгаа тохиолдолд шүүх санаачилгаараа шинжээч томилох асуудал байна. Хэргийг үнэн зөв мухарлаж шийдэхийн тулд шинжээч томилно. Эргэлзээ бүхий нөхцөл байдлыг тусгай мэдлэг бүхий этгээд эргэлзээг тайлна. Хэн ч харсан мэдэгдэхээр хуурамч гары үсэг байсан ч шүүх үүнийг чиний гарын үсэг биш байна хэмээн дотоод итгэлээрээ шийдэж болохгүй. Иргэний хэрэг дээр зайлиггүй нотолгооны үүрэг хуваарилалтынхаа дагуу нотлогдсон баримт дээр дүгнэж үнэлнэ”.</p>
<p>Асуулт: Шинжээч томилж буй маргаанаас хамгийн ээдрээтэй маргаан аль нь вэ?</p>
<p>Хариулт: “Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зөрүүтэй шинжээчийн дүгнэлт хамгийн их гардаг. Зах зээлийн хандлагын 3 арга байгаа хэдий ч энэ эд зүйл 500.000 төгрөгний үнэтэй байхад яг 500.000 төгрөгөөр үнэлээ гэсэн жишиг байхгүй байдаг. Үнийн дүн зөрүүтэй зарим тохиолдолд хэт дээд доор үнэлдэг. Жишээлбэл, автозасварын үнэлгээг авч үзье. Ланд 300 автомашины үнэлгээ нь бодит үнээр биш зах зээлийн ханиаар буюу хөөрөгдсөн дүнгээр тавьдаг зэрэг хөрөнгийн үнэлгээний дүн гардаг. Үнэлгээний компанийн стандартыг нэг мөр мөрдүүлэх тал дээр анхаарах шаардлагатай. Талууд өөрсдөө үнэлгээ хийлгээд ороод ирдэг. Хариуцагч талаас хэтэрхий өнлөр үнэлсэн байна, үнийн дүнг зөвшөөрөхгүй гэж маргадаг. Үүний үндсэн дээр хэргийн оролцогчийн хүсэлтийн дагуу шинжээч томилдог. Хувиараа үнэлгээ тогтоосон газрууд хүссэн үнээрээ үнэлдэг талууд уг үнэлгээг эс зөвшөөрч шүүхэд ханддаг”.</p>

Зураг 2. 1. Шинжээч томилуулах хүсэлтийн шинжилгээний төрөл⁵⁶

⁵⁶ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлсэн асуудал, (Улаанбаатар: 2015 он), 29 дэх тал



Д.Алтантуул шүүгчийн дурдсанчлан эцэг тогтоох шинжилгээг эргэлзээгүй нотлох баримтаар үнэлж байгаа нь онолын хувьд шинжлэх ухааны хувьд батлагдсан нь шүүгчийн субъектив үнэлгээнээс давуу эрхтэй буюу маргаангүйгээр үзэж болохоор байна. Гэвч ИХШХША-нд шинжээчийн дүгнэлт нь бусад нотлох баримтын адил шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон баримт биш бөгөөд шүүгч түүнийг үндэслэлтэй байдлынх нь хувьд заавал шалгах үүрэгтэй. Хөрөнгийн үнэлгээний дүн хэт зөрүүтэйгээр шүүхэд ирдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ихээхэн асуудал болдог ба жишиг үнэлэх үнэ байдаггүй байна. Шинжээч нь онолын хувьд шүүгчийн туслах нотолгооны хэрэгсэл болохоос, хэргийг эцэслэн шийдэгч биш тул шүүх гарын үсэг хуурамч болох нь энгийн нүдээр илэрхий байсан ч мэргэжлийн дүгнэлтээр баталгаажуулж байгаа нь нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэх хууль ёсны шаардлагыг хангах үндэслэл болж байна. Талуудын хүсэлтэд тулгуурлан шинжээч томилох нь ИХШХША-ны диспозитив зарчимтай нийцэж байгаа хэдий ч шүүхээс эрх зүйн туслалцаа үзүүлэх замаар талуудын мэдлэгийн дутмаг байдлыг нөхөж шинжээч томилуулах тухай санаачлагыг өгч байгаа нь хэргийн үнэн зөв байдлыг тогтоох нэг арга хэмжээ байна.

Шинжээчийг томилж тухайн нотолгооны зүйлийн эргэлзээг тайлах нь хэрэгт хэр их ач холбогдолтойг үндэслэн томилох бөгөөд хүсэлт болгоныг шүүх хангаж шийдвэрлэх боломжгүй. 2020 оноос 2025 оныг дуустал Д.Алтантуул шүүгч нийт шинжээч томилох хүсэлтийг шийдвэрлэсэн 17 захирамж байх ба шүүгчийн захирамж нэг бүрийг уншиж судаллаа.

Шүүгчийн захирамж 1. (Хүсэлтийг хангаагүй)

2021 оны ... дугаар сарын ...-ний 151/ШЗ2021/03222 дугаар захирамж

...Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.А нь “шинжээч томилуулах”, “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтүүдийг гаргасан байна.

Шинжээч томилуулах хүсэлтийн үндэслэлээ “...нярай хүүхдийн нэмэлт сүү, живх, хувцас зэрэг хэрэглээний зардалд хичнээн төгрөг зарцуулагддаг болохыг шүүхийн журмаар шинжээч томилуулан тогтоолгох” гэж тайлбарласан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1, 107 дугаар зүйлийн 107.2-д тус тус зааснаар нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн талд оролцож буй төлөөлөгч, өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэж байгаа үндэслэлээ нотолно гэж хуульчилсан.

Нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн талд оролцож буй төлөөлөгч нь өөрт байгаа, хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдолтой гэж үзсэн нотлох баримтаа өөрөө болон төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан шүүхэд гаргаж өгнө.

Хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий аливаа баримт мэдээлэл өөрт нь байхгүй байгаа тохиолдолд өөрийн биеэр болон төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан олж авна.

Нэхэмжлэгчийн төлөөлөгчийн Ж.Ариунбулагийн “...нярай хүүхдийн нэмэлт сүү, живх, хувцас зэрэг хэрэглээний зардалд хичнээн төгрөг зарцуулагддаг болохыг шүүхийн журмаар шинжээч томилуулах” тухай хүсэлт нь тусгай мэдлэгийн үнэлэлт шаардагдах асуудалд хамаарахгүй байна.

Мөн Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвөөс нотлох баримт гаргуулах хүсэлтийг гаргасан байх бөгөөд нэрлэн заасан нотлох баримт нь хэрэг хянан шийдвэрлэхэд зайлгүй шаардлагатай нотлох баримт гэж үзэх үндэслэлгүй, тухайн нотлох баримтыг өөрөө олж авах боломжгүй ямар хүндэтгэн үзэх шалтгаантай болох нь тогтоогдохгүй байна.

Иймд шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах хүсэлтүүдийг тус тус хангахаас татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй байна...

Шүүгчийн захирамж 2. (Хүсэлтийг хангасан)

2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн 317/ШЗ2025/00421 дугаар захирамж

...Хариуцагч Ц.М нь “шинжээч томилуулах” хүсэлтийг гаргасан.

Хэргийн оролцогчид зээлийн гэрээний үүрэг, гэрээний үүргийн зөрчлийг арилгахтай холбогдуулан хавтаст хэргийн 23-25, 28-29 дүгээр талд авагдсан баримтад зурагдсан гарын үсгийг зурсан эсэх талаар маргаж байна.

Хэрэгт авагдсан дээрх баримт нь тус хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой баримт байх боломжтой байх тул хүсэлтийг хангаж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг үндэслэн Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Кримниластикийн хэлтсийг шинжээчээр томилж, үүнтэй

холбоотойгоор хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхээр шийдвэрлэв.

Шинжээч “Х банк” ХХК дахь Банкны эрх хүлээн авагч нь Ц.М-д холбогдох иргэний хэргийн 23-25,28-29 дугаар талд авагдсан зээлийн гэрээ болон барьцааны гэрээн дээрх баримтын гарын үсэг нь хавтаст хэргийн 37, 38, 39 дүгээр талд зурагдсан хариуцагч Ц.М-ийн гарын үсгийн хэвтэй таарч байгаа эсэх талаар кримниластикийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж ирүүлэх шаардлагатай байна...

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа:

ИХШХША-ны хугацааг хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.⁵⁷ хэмээн зохицуулсан. Сүүлийн жилүүдэх шүүх дээр ирэх ачаалал нэмэгдсэнтэй холбоотойгоор мөн бусад хүчин зүйлсээс шалтгаалан ХХША-ны хугацаа удааширч байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь шинжээчийн дүгнэлт хугацаандаа ирэхгүй байх, нэмэлт болон дахин шинжилгээ хийх зэрэг ордог.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн”-ээс авсан “Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”-аас харахад судалгаанд хамрагдах хугацаанд улсын хэмжээнд анхан шатны шүүхүүд 43631 нэхэмжлэлийг хүлээн авч, 37009 буюу 84.8 хувьд нь иргэний хэрэг үүсгэсэн байна. Харин нийт 41433 шүүх хуралдааныг товлосноос 14940 удаа буюу 36.05 хувьд нь шүүх хуралдааныг хойшлуулжээ⁵⁸. Үүнээс шинжээч томилох хүсэлт гаргасантай холбоотой хойшилсон хэргийн тоо 121 байна.

Мөн шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс гаргасан “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” судалгаанд нийт 730 иргэнийг хамруулсан ба ИХШХША нь шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт өгсөнөөр хойшилсон хэрэг 1.6 хувийг⁵⁹ эзэлж байна.

Шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй эсхүл бүрэн бус тохиолдолд нэмэлт эсвэл дахин шинжилгээ хийлгэхээр шинжээчийг томилдог. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажлын хуагцаа сунах, удаашрах нэг шалтгаан нөхцөл болдог.

Шинжээчийн зардал:

⁵⁷ ИХШХШТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.1

⁵⁸ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа, 2015 он

⁵⁹ Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв, Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь, 2023 он

Шинжээчийн зардал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн зардалд хамаардаг бөгөөд үүнийг хэрхэн хуваарилах, хэн төлөх талаарх зохицуулалтыг ИХШХШТХ-ийн 53, 54, 56 дугаар зүйлүүдэд тусгасан байдаг. Шинжээч томилуулах хүсэлт гаргасан тал шинжилгээний зардлыг урьдчилан шүүхийн дансанд эсвэл шинжилгээний байгууллагад байршуулах үүрэгтэй. Харин эцсийн байдлаар шинжээчийн зардлыг ИХШХШТХ-ийн 56 дугаар зүйлд заасны дагуу хуваарилах ба дараах байдлаар хуваарилна. Үүнд:

- Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэвэл хариуцагч тал шинжээчийн зардлыг бүрэн хариуцна. Нэхэмжлэгчийн урьдчилан төлсөн зардлыг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгоно.
- Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэвэл шинжээчийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваарилна.
- Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэвэл нэхэмжлэгч тал зардлыг хариуцна.

2.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх судалгааны хэсгийн хүрээнд анхан шат, давж заалдах шат, хяналтын шат гэсэн гурван шатаар дамжин шийдвэрлэгдсэн нийт 25 шүүхийн шийдвэртэй танилцсан ба шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэсэн 6 шүүхийн шийдвэрийг сонгон шинжээчийн дүгнэлт нотолгооны хэрэгсэл болохын хувьд уг маргаанд нотлох баримтын эзлэх эрэмбэ хэр байна вэ? Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байна уу?, Ямар тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг үнэлж, ямар тохиолдолд чухал ач холбогдолтой биш гэж үзэж байна вэ?, зэрэг асуултуудад хариулах байдлаар дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Зураг 2. 2. *Шинжээч томилсон маргааны төрөл (2015 оны байдлаар)*⁶⁰

⁶⁰ Шүүхийн ерөнхий зөвлөл, *Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлсэн асуудал*, (Улаанбаатар: 2015 он), 31 дэх тал



Графикт харагдаж буй хамгийн өндөр хувийг эзэлж буй гэрээний маргаанд ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэрээтэй холбоотой маргаан, бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой маргаан эзэлж байна. Гэрээний бус үүрэгтэй маргаанд бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан гэх маргаан 83.8 хувийг эзэлж байна. Гэр бүлийн холбогдолтой маргаанд биологийн эцэг тогтоох, хөрөнгийн үнэлгээ хийлгэх, хүүхдийн асрамж тогтоох зэрэг маргаанууд байна⁶¹.

Шинжээч томилдог түгээмэл маргаанууд болох ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаан, гэм хор учруулснаас үүдсэн эд хөрөнгийн хохирол гаргуулах, хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох, худалдах худалдан харилцаатай холбогдсон маргааныг сонгож авсан болно.

Маргааны төрөл: Ажил гүйцэтгэх

Тохиолдол 1.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Монгол Улсын дээд шүүх, 2024 оны 10 сарын 01 өдөр, Дугаар 001/ХТ2024/00200⁶²

Маргааны агуулга:

2022 оны 03 дугаар сар: Нэхэмжлэгч С нь Хан-Уул дүүргийн 11-р хороо, Оргил хотхонд байрлах 1003 мкв талбайтай хувийн сууцандаа засвар хийлгэхийн тулд Интерьер дизайн комьонити ХХК-ийн захирал Б.Энхтөгөлдөрт ханджээ. Нэхэмжлэгч С нь "Интерьер дизайн комьонити" ХХК-тай 509 гаруй сая төгрөгийн засварын ажлыг амаар болон бичгээр гэрээлсэн боловч хугацаа хэтэрсэн, мөн дулааны шугам, тааз, шал эвдэрсэн зэрэг

⁶¹ Мөн тэнд, 32 дахь тал

⁶² Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 10 сарын 01 өдрийн 001/ХТ2024/00200 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

чанарын ноцтой гологдол гарсан тул дутуу ажлын хөлс, учирсан хохирол, алдангид нийт 400.3 сая төгрөгийг хариуцагчаас нэхэмжилсэн маргааныг гурван шатны шүүх хянан шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүх нь засварын ажлын гүйцэтгээгүй хэмжээ болон үнийн дүнг тодорхойлохоор Лэндс ХХК-ийг шинжээчээр томилсон байна. Анхны шинжээчийн дүгнэлтийг ажиллагааны журам зөрчсөн үндэслэлээр үнэлэх боломжгүй болсон тул нэмэлт дүгнэлт гаргуулсан ба Лэндс ХХК нь хана, тааз, цахилгаан, сан, шал, туслах материал гэсэн 6 ажлыг зах зээлийн хандлагын аргаар тооцоолж гүйцэтгэсэн ажлын дүнг 198,527,355 төгрөг, гүйцэтгээгүй үлдсэн ажлын дүнг 194,572,645 төгрөг хэмээн тогтоож дүгнэлт гаргажээ. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахдаа шинжээчийн дүгнэлттэй холбоотойгоор дараах шаардлагыг хариуцагч гаргасан байна.

- Шинжээч зах зээлийн үнийг тогтоохдоо жишиг 3 байгууллагаас үнийн санал авсан гэж дүгнэлтдээ заасан. Гэтэл тэдгээр байгууллагын 2 нь барилгын засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй болох нь тогтоогдсон байна. Тиймээс энэ аргачлалаар гаргасан дүгнэлтийг нотлох баримтаар үнэлэх боломжгүй.
- "Л" ХХК ба "Л үнэлгээ" ХХК хоёрын хооронд зөрүү Шүүгчийн захирамжаар "Л" ХХК-ийг шинжээчээр томилсон байтал хэрэгт "Л үнэлгээ" ХХК-ийн дүгнэлт ирүүлсэн. Ямар шалтгаанаар өөр байгууллага дүгнэлт гаргасан талаарх баримт хэрэгт огт авагдаагүй.
- Шүүгчийн захирамжид бүх талуудыг байлцуулан дахин үзлэг хийхийг заасан байтал "Л үнэлгээ" ХХК нь 2024.03.04-ний дүгнэлтийг гаргахдаа дахин сууцанд үзлэг хийлгүй, 2023.06.20-ны өдөр хийсэн өмнөх үзлэгийг үндэслэн дүгнэлт гаргасан байна мөн тэр өмнөх үзлэг нь зөвхөн нэг талыг оролцуулж, дутуу хийгдсэн байсан.
- Шүүгчийн захирамжид 5 асуудлаар дүгнэлт гаргуулахаар заасан боловч шинжээч хэд хэдэн асуудалд огт хариулаагүй, ялангуяа дулааны шугам эвдэрсэн, таазны хагарал, өрөө хоорондын дулааны ажлын дутагдал, 100 мкв шалны үнэ зэргийг тогтоогоогүй.
- Нэхэмжлэгч нь зах зээлийн үнийг биш, гэрээнд тохиролцсон төсвийн дагуу хийгдээгүй ажлын хөлсийг буцааж шаардсан. Гэтэл шинжээч гэрээний төсвийг дур мэдэн өөрчлөн зах зээлийн ханшаар тооцоолсон, тухайлбал гипсен хана, кнаф

чигжээс, гипсэн тааз зэрэг олон зүйлийн үнийг бууруулж үнэлсэн нь хууль зүйн үндэслэлгүй.

- Эдгээр учир дутагдалтай дүгнэлтийг анхан шатны шүүх үнэн зөв гэж дүгнэж, шийдвэрийнхээ үндэслэл болгосон нь хууль зүйн шаардлагыг хангаагүй. Мөн захирамжийн биелэлт хангагдаагүй байхад нэхэмжлэгч дахин хүсэлт гаргаагүй гэдгийг шалтгаан болгосон нь буруу.

Шинжээчийн дүгнэлтийн тухайд давж заалдах шатны шүүх:

Шинжээчийн дүгнэлт худал, буруу гарсан гэх үндэслэл тогтоогдоогүй. Хариуцагч нар тус дүгнэлтийг үгүйсгэж няцаасан баримтыг шүүхэд гаргаагүй. Анхан шатны шүүх шинжээчид эрх, үүрэг тайлбарлаж, хууль сануулсан, процессийн алдааг залруулсантай холбоотой баримтууд хэрэгт авагдсан байх тул шинжээчийн дүгнэлттэй холбоотой гомдлыг хангах боломжгүй гэж дүгнэсэн.

Дүгнэлт:

Иргэний хуулийн 343 дугаар зүйлд зааснаар ажил гүйцэтгэх гүйцэтгэгч нь захиалагчийн даалгавраар тодорхой ажлыг гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, захиалагч нь тухайн үр дүнг хүлээн авч хөлс төлөх үүргийг тус тус хүлээдэг⁶³. Ажил гүйцэтгэгч нь тогтоосон хугацаанд гүйцэтгэх, гэрээнд заасан шаардлагыг хангасан үр дүнг хүлээлгэх өгөх үүрэгтэй. Уг гэрээтэй холбоотой маргаанд яагаад шинжээч томилох шаардлага үүсдэг вэ?

- 343 дугаар зүйлийн дагуу захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авах үүрэгтэй. Тиймд маргаан үүсэх үед "яг ямар үр дүн гарсан бэ, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанар хангалттай байсан уу" гэдгийг тогтоох шаардлага гарна. Барилгын засвар зэрэг мэргэжлийн чиглэлд энэ асуудлыг шүүгч өөрийн мэдлэгээр тогтоох боломжгүй тул мэргэжлийн шинжээч шаардлагатай болдог. Дээрх ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой тохиолдлуудад шинжээчийн дүгнэлт хэрэгт ач холбогдол бүхий нотолгооны хэрэгсэл мөн байх бөгөөд шүүх үүнийг бусад баримтуудтай хамт үнэлдэг. Шүүх дүгнэлтийг талуудын тайлбар, банкны баримтуудтай харьцуулан нэхэмжлэгчийн шаардлагыг хангасан нь ИХШХШТХ-ийн хуулийн 37 дугаар зүйлийн нотлох баримтыг үнэлэх зарчимтай нийцэж байна.

⁶³ ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1

Маргааны төрөл: Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол

Тохиолдол 2.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 2020 оны 05 сарын 29 өдөр, Дугаар 1164⁶⁴

Маргааны агуулга:

2017 оны 07 дугаар сарын 14-нд Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байрны 38 тоот Т.Харцагынхаас ус алдаж, доод давхарын 34 тоот буюу нэхэмжлэгч Г.Ганболдын өмчлөлийн байранд орсон. Тухайн үед 34 тоотыг Н.Бат-Эрдэнэ 2016.07.19-өөс 2018.06.01 хүртэлх хугацаагаар түрээслэн амьдарч байсан. Ус алдсанаас болж 34 тоотын хана, тааз, паркетан шал гэмтэж хохирол учирсан. Т.Харцага хохирлыг даатгалаас барагдуулна гэж амласан боловч өнөөг хүртэл төлөөгүй тул нэхэмжлэгч шүүхэд ханджээ.

- Т.Харцагынхны алчуур хатаагч цоорч их хэмжээний ус алдсан, ОСНАА-н ХҮТ-5 ажилчид дуудлага хүлээн авч усыг хааж зогсоосон.
- 34 тоотын тааз, хана, паркетан шал гэмтсэн ба 2, 3 давхарын айлуудад хүртэл ус орсон.
- Т.Харцага өөрийн байрны дотор дүгнэлт гаргуулж ба дүгнэлтэд коридорын паркет хуулагдсан, нойлын өрөөний хаалга гажсан гэж тэмдэглэсэн.
- Нэхэмжлэгч өөрийн хөрөнгөөр паркетан шал болон бусад засварыг хийж дуусгасан ба нийт 2,088,600 төгрөг зарцуулсан.
- Н.Бат-Эрдэнэ түрээслэгчийн хувьд крант, хаалтуудыг 190,000 төгрөгөөр шинээр солиулсан гэжээ.

Т.Харцага: Наадмаар лагер гарч байсан тул гэртээ байгаагүй. Утсаар мэдэгдсэний дараа ирж шалгахад 00-ын өрөөнд бага зэргийн ус тогтсон байсан бас бусад өрөөнд, коридорт ус урсаагүй гэжээ. 34 тоотод орж үзэхэд зөвхөн 00-ын өрөөний таазнаас хэсэгхэн газар шаралсан байсан, тийм их хэмжээний ус алдаж паркетан шал, хана таазыг гэмтээх боломжгүй гэж маргасан. Мөн нэхэмжилсэн үнийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн маргажээ. Н.Бат-Эрдэнэ: Ус алдсан нь үнэн, хохирол учирсан нь үнэн гэж зөвшөөрсөн. Гэхдээ өөрөө нэг ч төгрөг төлөх ёсгүй харин Т.Харцага хохирлыг даатгалаас

⁶⁴ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 сарын 29 өдрийн 1164 дугаар магадлал, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

барагдуулна гэж амласан гэжээ. Мөн нэхэмжлэгч Г.Ганболд засвар хийх гэж түрээсийн хугацаа дуусахаас 1 сар гарангийн өмнө гаргасан тул сүүлийн 1 сарын түрээсийн мөнгөө буцааж авах хүсэлтэй гэв.

Хяналтын шатны шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүх 2017.07.14-нд 38 тоотын 00-ын өрөөний алчуур хатаагч цоорч ус алдсан, улмаар 34 тоотын хана тааз, паркетан шал, обой гэмтсэн үйл баримтыг дараах нотлох баримтуудын нийлбэрээр тогтоосон байна.

- Соёмбо даатгал ХХК-ийн бичгийн баримтууд
- ОСНААГ-ын ХҮТ-5-ийн №121 тоот дүгнэлт
- Гэрч О.Цолмонбаатарын мэдүүлэг
- Хариуцагч Н.Бат-Эрдэнийн тайлбар
- Нэхэмжлэгчийн зарлагын баримт, засварын гэрээ, акт
- Шинжээчийн 2020.02.17-ны өдрийн дүгнэлт

Т.Харцага гэм хор учруулаагүй гэж маргаагүй байх ба зөвхөн үнийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэж татгалзсанц учраас нэхэмжлэгч шинжээч томилуулах хүсэлт гаргаж, шүүх хүсэлтийг хангаж захирамж гаргажээ. Шүүх ИХШХШТХ-ийн 25.2.2, 38.1 дугаар зүйлүүдийг үндэслэн татгалзлын үндэслэлийг нотлох баримтаар нотлох үүрэг хариуцагч өөрт байдаг гэж дүгнэж, Т.Харцага татгалзлаа нотлох баримт гаргаж өгөөгүй тул шаардлагыг хангаж, ИХ-ийн 510.1 дүгээр зүйлийн дагуу гэм хор учруулсан этгээд хохирлыг мөнгөөр нөхөн төлөх үүрэгтэй хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн.

Шинжээчийн дүгнэлтийг шүүх үнэлж 2,088,600 төгрөгийг Т.Харцагаас гаргуулахаар шийдвэрлэсэн ба шинжээчийн ажлын хөлс 230,000 төгрөгийг нэхэмжлэгч төлсөн ба ИХШХШТХ-ийн 56 дугаар зүйлийн шүүх хариуцагчаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн.

Дүгнэлт: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасны дагуу осол, хэргийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан

арилгах үүрэгтэй⁶⁵. Гэм хорын хариуцлага үүсэхийн тулд санаатай буюу болгоомжгүй үйлдэл, нэхэмжлэгчид гэм хор учирсан байдал буюу хохирлын бодит хэмжээ мөн үйлдэл ба хохирлын хооронд шалтгаант холбоо үүссэн байх ёстой байдаг. Нэхэмжлэгч өөрт хохирол учирсан гэдгийг мэдэж байж ч тухайн хохирлын мөнгөн дүнг өөрөө тооцоолох боломжгүйгээс шалтгаалан мэргэжлийн тусгай мэдлэг бүхий шинжээчийн дүгнэлтийг гаргуулах хэрэгцээ шаардлага үүсдэг байна. Жишээлбэл, зам тээврийн ослын маргаанд нэхэмжлэгч машинд хохирол учирсан, яг 14,880,000 төгрөгийн хохирол учирсан гэдгээ нотлох үүргийг хүлээнэ. Дийлэнх тохиолдолд хариуцагч мөнгөн дүнг хүлээн зөвшөөрдөггүй ба шинжээч томилуулах хүсэлтийг гаргадаг.

Хохирлыг нөхөн төлөхдөө ИХ-ийн 510 дугаар зүйлийг баримлах бөгөөд бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх буюу адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлөх зохицуулалттай.

Маргааны төрөл: Өв залгамжлал

Тохиолдол 3.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Монгол Улсын дээд шүүх, 2025 оны 01 сарын 07 өдөр, Дугаар 001/ХТ2025/00018⁶⁶

Маргааны агуулга:

Талийгаач Д.А нь 2021 оны 11 дүгээр сарын 25-нд нас барсан. Нэхэмжлэгч М.А нь нас барагчийн төрсөн охин бөгөөд ИХ-ийн 520.1.1-д заасан хууль ёсны өвлөгч байна. Д.А 2009-2021 он хүртэл И.Ө-тэй хамтдаа амьдарч байсан боловч гэрлэлтийг албан ёсоор бүртгүүлээгүй, тус хамтын амьдралыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр урьд нь тогтоож байсан байна. М.А нь 2022 оны 07 дугаар сарын 29-нд нотариатад өв хүлээн авах хүсэлтээ бүртгүүлжээ. Нотариатч өвлүүлэгчийн хөрөнгийн гэрчилгээнүүдийг эх хувиар шаардахад тэдгээр нь И.Ө-д байгааг тогтоосон. И.Ө эх хувийг өгөхгүй байсан тул өвлөх эрхийн гэрчилгээ гаргуулах боломжгүй болж шүүхэд хандсан. М.А тухайн үед АНУ-д байсан бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан И.Ө-тэй ярилцсан боловч тохиролцоонд хүрч чадаагүй.

Хэргийг шүүхэд шийдвэрлэх явцад дараах маргаантай нөхцөл байдлууд тогтоогджээ.

⁶⁵ ИХ(2002)-ийн 497 дугаар зүйлийн 497.1

⁶⁶ Монгол Улсын дээд шүүхийн 2025 оны 01 сарын 07 өдрийн 001/ХТ2025/00018 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

- Д.А нэр дээр бүртгэлтэй хэд хэдэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө байгаа бөгөөнд үүнд орон сууц, тээврийн хэрэгсэл, өвөлжөөний газар, хөөрөг, алтан бөгж, мөнгөн аяга байна.
- Д.А 2013 оноос хөдөлмөрийн чадвараа 70% алдаж, хэвтрийн дэглэмд орж, 4 удаа хагалгаанд орсон И.Ө ганцаараа асарч, 150 сая гаруй төгрөгийн эмчилгээний зардал гаргасан гэж маргасан мөн Д.А нотариатаар батлуулаагүй гэрээслэл бичиж үлдээсэн бөгөөд шинжээчийн 2 удаагийн дүгнэлтээр Д.А-ын өөрийн гар бичмэл гэж тогтоогдсон.
- Д.А, И.Ө нар 2015 онд орон сууц, 2016 онд өвөлжөөний газар, 2018 онд тээврийн хэрэгсэл худалдаж авсан ба И.Ө эдгээрийг хамтын хөдөлмөрийн үр шимд олсон дундын өмч хэмээн маргаан үүсчээ.

Маргаан бүхий хөрөнгүүд нь Д.А дангаараа биш хамтдаа мал малласан орлогоор олж авсан дундын өмч тул гэрчилгээний эх хувийг М.А-д өгөх боломжгүй мөн Д.А нас барахаас өмнө бүх хөрөнгөө И.Ө-д үлдээнэ гэсэн агуулгатай гэрээслэл бичсэн байсан ба энэ нь шинжээчийн дүгнэлтээр Д.А-ын гар бичмэл гэж тогтоогдсон тул хүчин төгөлдөр гэж маргасан байна.

И.Ө-ийн сөрөг нэхэмжлэлийн тухайд гэвэл орон сууц, Toyota Hilux тээврийн хэрэгсэл, 2000 кв өвөлжөөний газрыг Д.А, И.Ө нарын хамтран өмчлөх дундын эд хөрөнгө мөн болохыг тогтоолгохыг шаардсан. Мөн эмчилгээний зардал 120,124,824 төгрөгийг М.А-аас гаргуулахаар шаардсан боловч сүүлд татгалзсан байна.

Энэ маргаан нь 3 шатны шүүхээр шийдвэрлэгдсэн ба хянанлтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Гар бичмэлийн шинжилгээний шинжээч хоёр удаа дүгнэлт гаргасан нь Д.А өөрийн гараар гэрээслэл бичсэн болохыг тогтоожээ. Давж заалдах шатны шүүх гэрээслэлийн агуулгыг ИХ-ийн 40.3-т заасан "нас барагчийн хүсэл зоригийн илэрхийлэл" хэмээн хүлээн авч дундын өмч болохыг тогтооход үндэслэл бүхий байна хэмээн үзэж иймээс шинжээчийн гар бичмэл тогтоосон дүгнэлт нь дундын өмчийн маргааны шийдвэрт нөлөөлөх баримт байна.

Шинжээчийн дүгнэлт ИХШХШТХ-ийн 37.2-д заасан нотолгооны хэрэгсэл болсон. Давж заалдах шатны шүүх шинжээчийн дүгнэлтийг гэрчийн мэдүүлэг, бичгийн баримтуудтай нийлүүлэн үнэлж дундын өмч болохыг тогтоосон ба

Дүгнэлт:

ИХ-ийн 520 дугаар зүйлд хууль ёсны өвлөгчийг, 523 дугаар зүйлд гэрээслэлийн шаардлагыг, 528, 530 дугаар зүйлд өвлөгчийн эрх үүргийг зохицуулсан ба өвийн маргаанд шинжээч дараах зорилгоор томилогддог:

- Гар бичмэлийн гэрээслэлийн жинхэнэ байдлыг тогтоох мөн нотариатаар батлуулаагүй гэрээслэлийн маргаанд гар бичмэлийн шинжилгээ зайлшгүй шаардлагатай болдог.
- Эд хөрөнгийн үнэлгээ, өвлөгдөх хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох
- Дундын өмчийн хувийг тогтоох буюу хамтдаа олж авсан хөрөнгөд тус бүрийн хувийг тодорхойлох зэрэгт томилдог байна.

Маргааны төрөл: Хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох**Тохиолдол 4.**

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Улсын дээд шүүх, 2023 оны 06 сарын 27 өдөр, Дугаар 001/ХТ2023/00135⁶⁷

Маргааны агуулга:

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэгч Н нь "Т" ХХК-ийн өмчлөлийн 7 нэр төрлийн 4,410,348,867.98 төгрөгийн үнэлгээтэй тоног төхөөрөмжийг битүүмжлэн хурааж, дараах 3 үл хөдлөх хөрөнгийг үнэлүүлэхээр шийдвэр гүйцэтгэгч 3/218 дугаартай "Шинжээч томилох тухай" тогтоол гарган "С" ХХК-ийн үнэлгээч Г.О-г шинжээчээр томилсон. "С" ХХК газрыг хасч дан барилгыг 934.8 сая төгрөгөөр үнэлснийг төлбөр төлөгч "Т" ХХК хэт доогуур хэмээн эсэргүүцэж, шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг хуулийн дагуу явагдсан гэж маргасан хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс уг үнэлгээг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ

Давж заалдах шатны шүүх анхан шатны шийдвэрийг өөрчилж нэхэмжлэлийг хангасан ба нэхэмжлэлийн үндэслэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолд үл хөдлөх хөрөнгийг газрын хамт үнэлэхийг заасан байтал шинжээч газрын үнэ цэнийг үнэлгээнд оруулаагүй нь тогтоолд заасан үнэлгээ хийгдсэн гэж үзэх боломжгүй байна.

⁶⁷ Улсын дээд шүүхийн 2023 оны 06 сарын 27 өдрийн 001/ХТ2023/00135 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

- Шийдвэр гүйцэтгэгч тухайн үл хөдлөх хөрөнгө байршиж буй газрын эрхтэй холбоотой баримтыг холбогдох байгууллагаас тодруулаагүй. Газрын мэдээллийг тодруулаагүй нөхцөлд гарсан үнэлгээ үнэн зөв, бүрэн дүүрэн гарсан гэж үзэх мөн боломжгүй байна.
- Анхан шатны шүүх баримт хэрэгт авагдаагүй байхад нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь ч үндэслэлгүй.

Энэ хэргийн онцлог нь шинжээч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд томилогдсон. ИХ-ийн 177.1-д зааснаар дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох доод үнийг тогтоохдоо тохиролцоо байхгүй тохиолдолд үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийг баримтална хэмээн заасан. Энэ тохиолдолд "Т" ХХК үнийн санал ирүүлэлгүй тул шийдвэр гүйцэтгэгч шинжээч томилсон байна.

Уг шинжээчийн дүгнэлт нь шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолд заасан асуултын хүрээнд үл хөдлөх хөрөнгийг газрын хамт үнэлэхийг заасан байтал газрын мэдээлэл байхгүй, ирээгүй тул дан барилга болно" гэж тэмдэглэж газрыг үнэлгээнд оруулаагүй. Энэ нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-д заасан дагуу "шинжээчид тавьсан асуулт тус бүрд хариулт өгнө" гэснийг биелүүлээгүй байна. Тиймээс хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8.2.3-д заасан үнэлгээ "зохих үндэслэлтэй, тодорхой" байх шаардлагыг хангаагүй байна.

Дүгнэлт: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинжээч нь ИХ-ийн 177.1 болон ШШГТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.7-д зааснаар дуудлага худалдааны доод үнийг тогтоох зорилготой процесс болон гүйцэтгэлийн холбоотой.

Энэ хэрэгт шинжээч нь шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолд үндэслэн томилогдсон тул тогтоолд заасан даалгаврыг биелүүлэх үүрэгтэй байсан ба шинжээч нь томилсон этгээдийн тогтоолд заасан асуултын хүрээнд шинжилгээ хийх үүрэгтэй.

Маргааны төрөл: Хүүхдийн асрамж, тэтгэмж тогтоолгох

Тохиолдол 5.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Улсын дээд шүүх 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Дугаар 001/ХТ2024/00142⁶⁸

⁶⁸ Улсын дээд шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 001/ХТ2024/00142 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

Маргааны агуулга:

Нэхэмжлэгч Д болон хариуцагч Х нар 2007 онд танилцаж хамтран амьдарч эхэлжээ. 2011.09.28-нд охин Ц төрсөн. Талууд гэрлэлтээ бүртгүүлээгүй байсан бөгөөд 2012 оноос таарамжгүй харилцаанаас болж тусдаа амьдарч эхэлсэн ч охин Ц 2012.12.24-нөөс хойш эцэг Х-ын асрамжид амьдарч байв. Д нь 2013 оны эхээр Х архи уугаад гэртээ ирж хутга барин баруун гарыг нь зүсэж гэмтээсэн гэж мэдүүлээд үүнээс хойш 2017 он хүртэл охинтойгоо заримдаа уулзаж байсан ч 2017 оноос Х утсаа авахгүй болж, хаяг нь тодорхойгүй болсон. 2021 оны 11 сард Х-ын хамтран амьдрагч нэртэй эмэгтэйн тусламжтайгаар охинтойгоо нууцаар уулзахад охин "ээжтэйгээ хамт баймаар байна" гэж хэлсэн гэж Д мэдүүлжээ. Ингэхэд Д нь 2021.03.01-нд шүүхэд өргөдөл гаргасан байна.

Охин Ц 2012 оноос хойш 10 гаруй жил эцэг Х-ын асрамжид өссөн, цэцэрлэг, сургуульд явсан, эрүүл саруул өсч байгаа. Х нь байнгын ажлын байранд ажилладаггүй, сард 14 орчим хоног хөдөө ажилладаг бөгөөд охинтойгоо хамт байх хугацаа нь бага байдаг. Х удаа дараа Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргаж байсан гэжээ.

Сөрөг нэхэмжлэлийн тухайд:

Хариуцагч Х нь шүүхэд сөрөг нэхэмжлэл гаргасан ба охиныг өөрийн асрамж дээр үлдээлгэхийг хүсчээ.

Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангаж хариуцагчаас шинжээчид төлсөн зардлыг гаргуулахаар шийдвэрлэжээ. Харин давж заалдах шатны шүүх охиныг хариуцагчийн асрамжид хэвээр үлдээж анхан шатны шийдвэрийг өөрчлөн шийдвэрлэсэн ба хянанлтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Дүн шинжилгээ:

- Давж заалдах шатны шүүх охин Ц-ийг 16 нас хүртэл амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр эх Д-ээс сар бүр тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн. Гэр бүлийн тухай хуулийн 38.1-д зааснаар хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ тэтгэлгийг хамт шийдвэрлэх нь хуульд нийцнэ.
- Гэр бүлийн тухай хуулийн 38.1-д зааснаар хүүхдийн асрамжийг шийдвэрлэж байгаа тохиолдолд тэтгэлгийг хамт шийдвэрлэх нь хуульд нийцнэ. Гэр бүлийн тухай хуулийн 40.1.1, 40.1.2-т зааснаар тэтгэлэг тогтоож эх Д-ээс гаргуулах нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх үзсэн байна.

Шинжээчийн дүгнэлтийн тухайд – Гурав дахь удаагаа томилсон шинжээч охиныг аавдаа илүү дассан, илүү хамт байхыг хүсдэг хэмээн дүгнэлтдээ оруулжээ. Харин өмнөх

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 11 сарын 24-ний дүгнэлтэд охин өөрийн бодол хүслээр биш өөр хэн нэгний хариулж нөлөөнд орж хариулж байгаа байдал ажиглагдсан гэж бичсэн. Гурван шинжээчийн дүгнэлтийн нийлбэр дүнг баримтлан эхний 2 шинжээч нь аль алиных нь асрамжид зохистой гэж дүгнэн, 3 дахь нь аавдаа илүү дассан, хамт байх хүсэлтэй гэж үзжээ. Ерөнхий дүгнэлт нь одоо байгаа асрамжийг өөрчлөх ноцтой шалтгаан тогтоогдоогүй гэж үзэж давж заалдах шатны шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.16 дугаар зүйлд заасны дагуу “хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах, тэтгэлгийн хэмжээг тогтоох асуудлыг шүүх шийдвэрлэнэ”. Хүүхдийг хэний асрамжид үлдээх талаар зохигчид харилцан тохиролцож чадаагүй бол шүүх шийдвэрлэх ба эцэг, эхийн хүмүүжил боловсрол, амьдралын нөхцөл бололцоо, хүүхдийг эд хөрөнгө, сэтгэл санааны дарамтанд байлгадаг, эрх чөлөөнд нь халдаж, эрүүл мэнд, сэтгэл санааны гэм хор учруулж байсан эсэх, хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндэд анхаарал, халамж тавьдаг зэргийг тогтоолгохын тулд шинжээчийг томилох шаардлага гардаг. Түүнчлэн хүүхэд аюулгүй орчинд эрүүл саруул өсч, сурч боловсрох боломжийг анхааран үзэж, зохигчдын хэн нь дээрх шаардлагыг илүү хангаж байгааг харгалзан үздэг байна. Шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргах нэг чухал нотолгооны хэрэгсэл болдог байна.

Маргааны төрөл: Худалдах, худалдан авах гэрээ, арилжааны гэрээ

Тохиолдол 6.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Монгол Улсын дээд шүүх, 2024 оны 04 сарын 09 өдөр, Дугаар 001/ХТ2024/00071⁶⁹

Маргааны агуулга:

2017 онд "Б" ХХК болон иргэн М.А нарын хооронд "Орон сууц захиалгаар бариулах" гэрээ байгуулагдсан. Гэрээнд орон сууцны талбайг 88.71 м.кв, 1 м.кв-ын үнийг 2,400,000 төгрөг, нийт үнийг 212,904,000 төгрөг байхаар тохирчээ. Хариуцагч М.А нь нийт

⁶⁹ Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 04 сарын 09 өдрийн 001/ХТ2024/00071 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

190,000,000 төгрөг төлсөн ба үлдэгдэл төлбөрийн маргаан үүсчээ. Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр талбайг 79 м.кв гэж бичүүлсэн байх ба гэтэл бодит байдал дээр талбай илүү том гэж нэхэмжлэгч маргажээ. Харин хариуцагч тал 3 жилийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан учир хүлээн зөвшөөрөхгүй хэмээн маргажээ.

Давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалтад хариуцагчаас 18,680,000 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэж, үлдэх 15,676,000 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх шинжээчийн дүгнэлтийг үндэслэх хэсэгтээ оруулаагүй буюу үнэлж дүгнэлт өгөөгүй. Хугацаа дууссан гэж үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Дүн шинжилгээ:

- Шүүхээс "Уран Асар" ХХК-ийг шинжээчээр томилсон бөгөөд шинжээч талбайг 86.95 мкв гэж тогтоож дүгнэлт ирүүлсэн байна.

Шүүх энэхүү 86.95 мкв хэмжээтэй гэж тогтоосон шинжээчийн дүгнэлтийг үндэслэн нотлох баримтын хүрээнд үнэлж шийдвэрлэжээ. Мөн хариуцагч энэ дүгнэлтэд маргаж, дахин шинжээч томилуулах хүсэлт гаргаагүй байна. Нэхэмжлэлийн нэхэмжлэлийн шаардлагаас мкв-ийн зөрүүг хасч хариуцагчаас нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.

Дүгнэлт: ИХ-ийн 243 дугаар зүйлд худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулсан байдаг бөгөөд худалдагч тал биет байдлын болон эрхийн доголдолгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг шилжүүлэх, худалдан авагч тал хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээдэг⁷⁰. Худалдан авсан бараа, техник, үл хөдлөх хөрөнгө нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй эсвэл гэрээнд заасан шинж чанартаа хүрэхгүй байх тохиолдолдоор маргаан гарсан тохиолдолд шинжээчийг томилдог. Тухайлбал, автомашин худалдаж автал хөдөлгүүр нь гэмтэлтэй байх, эсвэл орон сууцны талбайн хэмжээ дутах зэрэг нь түгээмэл гардаг маргааны жишээ байна. Шинжээч нь доголдлыг тогтоох, үнэлгээг хийх, талбайн хэмжээг тогтоох зэрэг шүүгчийн эзэмшээгүй нарийн ур чадвар шаардах нотолгооны зүйлийг тогдооно. Мөн худалдан авагч хөрөнгөө хүлээн авсан боловч мөнгөө бүрэн төлөхгүй байвал шүүхэд ханддаг ба хэрэв гэрээнд заасан хугацаа дууссан

⁷⁰ ИХ(2002)-ийн 14 дүгээр зүйлийн 14.16

тохиолдолд ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.6-д заасны дагуу нэмж алданги тооцох эрхтэй байдаг.

Маргааны төрөл: Түрээсийн гэрээ

Тохиолдол 7.

Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн огноо:

- Улсын дээд шүүх, 2024 оны 06 сарын 18 өдөр, Дугаар 001/хт2024/00148⁷¹

Маргааны агуулга:

Нэхэмжлэгч нь Нийслэлийн өмч болох "Урт цагаан" (У төв)-ын 2, 3 дугаар блокийг эзэмшиж, ашиглах хугацаандаа 20 гаруй жилийн турш их засвар хийж, хөрөнгө оруулалт оруулсан. Тус барилгыг ашиглах боломжгүй болсон ба ашиглалтын шаардлага хангахгүй, нурах эрсдэлтэй гэх мэт шалтгаанаар буулгахаар болсон тул талуудын хоорондох гэрээ цуцлагджээ. Гэрээ цуцлагдсаны дараа нэхэмжлэгч тал "Миний оруулсан хөрөнгө оруулалт, засан сайжруулалтын өнөөгийн үнэ цэнэ 4.09 тэрбум (эсвэл шинжээчийн тогтоосноор 2.01 тэрбум) төгрөг болсон тул үүнийг Нийслэлээс гаргуулж өг" гэж шаардсан. Харин хариуцагч тал Нийслэлийн Засаг дарга үүнийг зөвшөөрөөгүй байна.

Хяналтын шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Энэхүү хэрэгт Урт цагааны 2, 3 дугаар блокийн барилгын үнэ цэнийг тогтоохоор "Т" ХХК, "Г" ХХК, "Ц" ХХК гэсэн 3 өөр шинжээч томилогдон ажилласан бөгөөд тэд барилгын үнийг 2.01 тэрбумаас 4.09 тэрбум төгрөгийн хооронд маш зөрүүтэй үнэлсэн байна. Нэхэмжлэгч Иргэний хуулийн 94 дүгээр зүйлийн 94.4-т зааснаар "хөрөнгийг буцааж өгөх үеийн үнэлгээгээр" буюу өнөөгийн зах зээлийн ханшаар тооцож, барилгын засан сайжруулалтын үнийг тэрбумаар хэмжигдэх дүнгээр авах ёстой гэж маргасан. Анх 2004 онд байгуулсан гэрээгээр "зөвхөн их засварт гаргасан бодит зардлыг" л тооцохоор тохирсон. Барилга өөрөө элэгдэж хуучирсан, нурах дөхсөн байхад өнөөгийн зах зээлийн ханшаар тэрбум төгрөг нэхэж байгаа нь үндэслэлгүй гэж маргажээ.

Давж заалдах шатны шүүх барилгын өнөөгийн үнэ цэнийг тогтоосон шинжээчийн үнэлгээг баримтлах нь зөв гэж үзсэн бол Улсын Дээд шүүх шинжээчийн гаргасан зах

⁷¹ Монгол Улсын Дээд Шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 001/хт2024/00148 дугаар тогтоол, [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

зээлийн үнэлгээг үгүйсгэж, талуудын анхны гэрээний тохиролцоо болон бодит зардлын баримт болох 2004 оны Хөрөнгө оруулагчийн гэрчилгээнд заасан 477.3 сая төгрөгийг олгох нь хууль зүйн хувьд зөв гэж шийдвэрлэсэн байна. Энэхүү маргааны агуулга нь түрээсэлж байсан төрийн өмчийн барилгад хийсэн их засварын зардлыг буцаан олгохдоо "өнөөгийн зах зээлийн ханшаар дахин үнэлсэн 4 тэрбум төгрөгөөр олгох уу" эсвэл "анх гаргасан бодит зардал болох 477.3 сая төгрөгөөр олгох уу" гэдгийг шийдвэрлэх, мөн үүнтэй холбоотойгоор үүссэн түрээсийн төлбөрийн үлдэгдлийг тооцож суутгах тухай маргаан гэж дүгнэж болохоор байна. Анхан шатны шүүх "Цэгц-Очир" ХХК болон бусад шинжээчийн гаргасан тэрбумаар хэмжигдэх үнэлгээнүүдийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохоос татгалзсан. Үүний шалтгаанаа үндэслэх хэсэгтээ дараах байдлаар тайлбарлажээ:

- Инфляцыг хийсвэрээр тооцсон: Шинжээчид 1998-2004 оны хооронд хийгдсэн засварын зардлыг өнөөдрийн (2020 оны) ханшид шилжүүлэхдээ зөвхөн инфляцын индекс, үнийн өсөлтийг механикаар бодож, хийсвэрээр өсгөсөн гэж үзэв.
- Барилгын бодит элэгдлийг тооцоогүй: "Урт цагаан" үйлчилгээний төвийн барилга нь ашиглалтын шаардлага хангахгүй болж, Мэргэжлийн хяналтын дүгнэлтээр нурах эрсдэлтэй, үйл ажиллагааг нь зогсоох шаардлагатай болсон байсан. Шинжээчид үнэлгээ хийхдээ энэхүү барилгын бодит муудалт, элэгдэл хорогдлыг бодитой тусгаж чадаагүй гэж шүүх дүгнэжээ.

Шүүх үнийг хийсвэрээр тааж эсвэл дахин үнэлж тогтоогоогүй. Нэхэмжлэгч "Анома" ХХК нь 1998-2004 оны хооронд "Урт цагаан"-ы 2, 3 дугаар блокт бодитоор их засвар хийсэн бөгөөд үүнийг нь Нийслэлийн Засаг дарга 2004 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 24 тоот "Хөрөнгө оруулалтын гэрчилгээ"-гээр баталгаажуулж байжээ. Уг гэрчилгээнд заасан бодит зардлын дүн нь 477,304,107 төгрөг байсан бөгөөд энэ дүнг талууд аль аль нь тухайн үедээ хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан байсан тул шүүх үүнийг "хэрэгт авагдсан хамгийн бодитой, хууль ёсны баримт" гэж үзсэн. Шүүх үнэ тогтоохдоо нэхэмжлэгч талын барьж байсан Иргэний хуулийн 94.4 дүгээр заалтыг (эд хөрөнгө буцааж өгөх үеийн зах зээлийн үнэлгээгээр шаардах) бус, харин Иргэний хуулийн 289 дүгээр зүйлийн 289.2.5-д заасныг баримталсан. Уг заалтад: Түрээслэгч нь түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр эд хөрөнгийг засаж сайжруулахад гаргасан "зайлшгүй зардлаа" гэрээ дуусгавар болсны дараа төлүүлэхээр шаардах эрхтэй гэж заасан байдаг. Шүүх үүнийг тайлбарлахдаа: Зайлшгүй зардал гэдэг нь тухайн үед

засвар хийхэд бодитоор гарсан зардал болохоос биш, ирээдүйд инфляцаар өсгөж бодох хийсвэр үнэ биш гэж үзсэн байна.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх хэсгийг нэгтгэн дүгнэвэл:

Дээрх шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх явцад шинжээчийн дүгнэлт нь маргаан болгонд харилцан адилгүй байр суурь, нотлох үүрэгтэй байна. Эцэг тогтоох тал дээр шинжээчийн дүгнэлт буюу шүүх шинжилгээг шууд нотлох баримтаар тооцож үнэлж болохоор байгаа ч хүүхдийн асрамж тогтоолгох маргааны хувьд шинжээчийн дүгнэлт гэхээс илүү гэрчийн мэдүүлгийг нотлох голчлон үндэслэх ба шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын эх сурвалжийн үүргийг гүйцэтгэж байна.

Шүүх шинжээчийн дүгнэлтийг эргэлзээтэй, бүрэн бус гэж үзвэл нэмэлт эсвэл дахин шинжилгээг хийлгэдэг. Харин шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд талууд уг дүгнэлт дээр маргавал дээд шатны шүүхэд гомдол гаргаж байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шинжээчийн дүгнэлтийг хүчингүй болгуулах, гэм хор учруулсны хохирлын дүн, худалдах худалдан авах гэрээний зүйлийн үнэ, ажил гүйцэтгэх гэрээний зүйлийн дүн зэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжээчийн үнэлсэн дүгнэлтийн хэмжээтэй талууд их маргаж байна. Д.Алтантуул шүүгчийн дурдсанчлан хөрөнгийн үнэлгээний нэгдмэл биш байдал, шинжээч, үнэлгээчдэд зориулсан эдийн болон эдийн бус хөрөнгийн үнийг тогтоосон баримтлах жишиг дутмаг байдгаас үүдэн маргаан илүү удааширдаг гэж ажиглагдаж байна.

Мөн шинжээчид эрх үүрэг сануулаагүй буюу Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар шинжээчид "Худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуулийн 21.4-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэдгийг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулаагүй бол уг дүгнэлтийг шүүх шууд үнэлэхгүй хасдаг. Шинжээч нь хэргийн оролцогч талуудын төрөл садан, ашиг сонирхол нэгтэй, эсхүл урьд нь тухайн хэрэгт өөр байр сууринаас оролцож байсан бөгөөд ИХШХШтХ-ийн 26 дугаар зүйлд заасан татгалзан гаргах нөхцөл байдал илэрвэл дүгнэлт хүчингүй болдог байна. Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан тусгай мэдлэг эзэмшсэн шинжээчийн эрхгүй этгээдийн хийсэн дүгнэлтийг шүүх үнэлдэггүй байна. Шүүгч дотоод итгэлээрээ дүгнэлтийн логик уялдааг шалгах явцад дараах дутагдал илэрвэл шийдвэрийн үндэслэл болгодоггүй. Шинжээчийн дүгнэлтийн судалгааны хэсэгт хийсэн техникийн задлан

шинжилгээ нь төгсгөлд нь өгсөн нэгдсэн хариулттайгаа авцалдахгүй, зөрүүтэй байвал шүүх уг дүгнэлтийг няцаана. Дүгнэлт нь шинжлэх ухааны баримт, тооцоолол дээр биш, ерөнхий таамаг дээр үндэслэгдсэн байвал үнэлэхгүй. Жишээлбэл хурдны хайрцгийг *"бараг л ийм шалтгаанаар эвдэрсэн байх магадлалтай"* гэх зэргээр эргэлзээтэй бичсэн байвал шүүх түүнийг нотлох баримтаар авахгүй.

Хэргийн оролцогч шинжээчийн дүгнэлтийг няцаасан өөр хууль ёсны баримтууд гаргаж өгсөн, эсхүл шүүх хуралдааны явцад шинжээчийн ашигласан аргачлал буруу байсныг нотолж чадвал шүүх дүгнэлтийг үнэлэхгүй байх эрхтэй байдаг байна. Үүнээс үүдэн гарч буй үр дагавар нь нэг талаараа шинжээчийн дүгнэлт маргааны төрлөөс хамааран өөр өөр байр суурийг эзэлдэг, нөгөө талаас дахин шинжилгээ хийлгэх үндэс болж байна гэж үзэж байна.

2.3. Харьцуулсан судалгаа

Монгол Улс бол Эх газрын эрх зүйн бүл Civil Law, тэр дундаа Герман-Ромын эрх зүйн тогтолцоонд ахмаардаг. Манай улсын 2002 оны Иргэний хууль нь Германы Иргэний хуулийн үзэл баримтлал, бүтэц дээр тулгуурлан боловсруулагдсан билээ. Хууль нь өөрөө Герман улсын Иргэнийн хуулийн суурь загвартай тул түүнийг хэрэгжүүлэх "процесс ажиллагаа" буюу ИХШХШТХ хууль нь мөн Герман улсын процесс ажиллагаатай ойр илүү нийтлэг шинжтэй байна гэж үзсэн учраас ХБНГУ-ын ИХШХШТХ-ийн шинжээчтэй холбоотой зохицуулалтыг өөрийн улсын зохицуулалттай харьцуулан энэхүү бүлэгт судаллаа.

2.3.1. Бүгд Найрамдах Герман улсын эрх зүйн зохицуулалт

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын ИХШХША-нд шинжээч, шүүхийн шинжилгээтэй холбоотой харилцааг Иргэний хэргийн кодекс буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Zivilprozessordnung), Шүүхийн зардлыг нөхөн төлөх, урамшуулах тухай хууль (Justizvergütungs-und-entschädigungsgesetz) болон Иргэний хууль (Bürgerliches Gesetzbuch)-иудаар мөн холбоотой журмуудаар нарийвчлан зохицуулдаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын иргэний процесс ажиллагаанд шинжээчийг сонгох болон шинжээчдийн тоог тогтоох асуудлыг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх шийдвэрлэдэг ба мөн тусгай мэдлэгийн хэрэгцээний хүрээнд шаардлагатай үйл баримтыг тодруулахын тулд томилно. Шинжээчийг томилохоос өмнө

талуудаас тухайн шинжээчийн талаар саналыг сонсдог ба шүүх нь шинжээчээр ажиллахад тохирох этгээдийн нэрийг дэвшүүлэхийг талуудаас шаардаж болно. Хэрэв талууд тодорхой этгээдийг шинжээчээр томилох талаар харилцан тохиролцсон бол шүүх уг тохиролцоог заавал дагаж мөрддөг байна.⁷² Тус ажиллагаанд шинжээчээр томилогдсон этгээд нь тухайн төрлийн шинжилгээний дүгнэлт гаргахаар нийтийн өмнө томилогдсон, эрх олгогдсон, шинжилгээ хийхэд шаардлагатай шинжлэх ухаан, урлаг эсхүл мэргэжлийн үйл ажиллагааг эрх ашгийн төлөө нийтэд нээлттэй эрхэлдэг байх ёстой бөгөөд шүүхийн өмнө дүгнэлт гаргаа илэрхийлж зөвшөөрөн дүгнэлт гаргах үүргийг заавал хүлээнэ⁷³.

Шинжээч нь дүгнэлт гаргахаас өмнө эсвэл гаргасны дараа тангараг өргөнө. Тангараг нь шинжээч өөрт даалгасан дүгнэлтэд хайхрамжгүй өнгөц хандах, өөрийн мэдлэг, ухамсартаа тулгуурлан үнэн зөв гаргаа амлах эсвэл гаргаснаа батлахад оршдог. Хэрэв шинжээч тухайн төрлийн дүгнэлт гаргахаар ерөнхий байдлаар тангараг өргөсөн бол өмнө өргөсөн тангарагтаа эш татахад хангалттай байдаг байна.⁷⁴

2.3.2. Шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх

Шинжээч өөрийн шинжлэн судалсан зүйл, судалгааны явц, ашигласан арга техник болон түүний үндсэн дээр гаргасан оюун дүгнэлтээ багтаасан бичмэл баримт бичгийг шинжээчийн дүгнэлт гэж хэлнэ⁷⁵. Бичгээр гаргах шинжээчийн дүгнэлтийн хувьд шүүх бичгээр шинжилгээ хийхээр захирамжилсан бол шинжээч өөрийн гарын үсэг тогтоох зурсан дүгнэлтийг ирүүлэх хугацааг шүүх тогтоодог байна. Шүүх нь шинжээчийн үйл ажиллагааг удирдах бөгөөд түүний үйл ажиллагааны хэлбэр, цар хүрээний талаар зааварчилгаа өгч болно. Хэргийн онцлогоос шалтгаалан шүүх шинжилгээний асуултыг томъёолохоос өмнө шинжээчийн саналыг сонсож, түүнд үүрэг даалгаврыг нь танилцуулж, шинжээчийн хүсэлтээр даалгаврыг тайлбарлаж өгөх ёстой ба хэргийн нөхцөл байдал маргаантай байгаа тохиолдолд шинжээч дүгнэлт гаргахдаа ямар баримтуудыг үндэслэх ёстойг шүүх тогтооно. Шаардлагатай тохиолдолд шүүх шинжээч тухайн асуултыг тодруулахын тулд ямар бүрэн эрхтэй байх, талуудтай ямар хэмжээнд харилцаж болох, мөн шинжилгээний явцад талуудыг хэзээ оролцуулахыг тогтооно. Шинжээчид өгсөн зааварчилгааг талуудад мэдэгдэх ёстой ба хэрэв шинжээчид үүрэг

⁷² § 404 Absatz 1 Satz 1 ZPO [§ 404 ZPO - Einzelnorm](#)

⁷³ § 404 Abs. 1 S. 2 ZPO [§ 404a ZPO - Einzelnorm](#)

⁷⁴ § 410 Abs. 1 ZPO [§ 410 ZPO - Einzelnorm](#)

⁷⁵ § 411 Abs. 1 ZPO [§ 411 ZPO - Einzelnorm](#)

даалгавар танилцуулах тусгайлсан тов тогтоосон бол талуудыг оролцохыг зөвшөөрдөг байна⁷⁶. "Хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь нотлох баримт цуглуулах үүрэг хүлээсэн шүүгчид шинжээчийг томилох эрхийг олгож болно. Энэ тохиолдолд тухайн шүүгч нь ИХШХШТХ-ийн 404 болон 404а дүгээр зүйлд заасан шүүхийн бүх эрх мэдэл, үүргийг хэрэгжүүлнэ⁷⁷.

Шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан бүх нөхцөл байдал, агуулга болон нотлох баримтыг шинжлэн судалсан үр дүнг харгалзан үзэж, тухайн үйл баримт үнэн эсвэл худал болохыг өөрийн дотоод итгэлээр үнэлэн шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэрт шүүгчийн дотоод итгэл үнэмшил бүрдэхэд нөлөөлсөн үндэслэлүүдийг тодорхой зааж өгсөн байна⁷⁸. Шинжээч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд ирээгүй, эсвэл дүгнэлт гаргах үүрэгтэй байсан ч татгалзсан, эсвэл хэргийн материал болон бусад баримт бичгийг буцааж өгөхгүй саатуулсан бол үүнээс үүдэн гарсан бүх зардлыг тухайн шинжээчээр төлүүлнэ. Үүний зэрэгцээ түүнд сахилгын торгууль ногдуулдаг⁷⁹. Хэрэв уг зөрчлөө давтан гаргавал сахилгын торгуулийг дахин ногдуулж болно. Хэрэв дүгнэлт гаргах үүрэг хүлээсэн шинжээч тогтоосон хугацааг хэтрүүлбэл түүнд сахилгын торгууль мөн ногдуулдаг. Торгууль ногдуулахаас өмнө шинжээчид нэмэлт хугацаа тогтоож, торгууль ногдуулахыг урьдчилан анхааруулсан байх ёстой. Хугацааг удаа дараа хэтрүүлбэл торгуулийг дахин ногдуулж болно. Нэг удаагийн торгуулийн хэмжээ 3000 еврогоос хэтрэхгүй байна. Шүүх бичгээр гаргасан дүгнэлтийг тайлбарлуулах, бичгээр нэмэлт тайлбар авах эсвэл дүгнэлтийг нөхөн гүйцэтгүүлэх зорилгоор шинжээчийг биечлэн ирэхийг шаардаж болно. Мөн § 128а-д заасны дагуу шинжээчийг дүрс, дууны дамжуулалтаар цахимаар оролцуулахыг зөвшөөрч эсвэл захирамжилж болно⁸⁰. Мөн шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэх ажиллагаанд өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шинжээчийн дүгнэлтийг орлуулан ашиглаж болох ба энэ тухай ХБНГУ-ын ИХШХШ тухай хуулийн 411а дугаар зүйлд хуульчилсан байх ба бичгээр гаргах шинжилгээг өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх эсвэл прокурорын байгууллагаас гаргуулж авсан шинжээчийн дүгнэлтээр орлуулж болно. Шүүх шинжээчийн дүгнэлтийг хангалтгүй гэж үзвэл тухайн шинжээчээр, эсвэл өөр шинжээчээр дахин шинжилгээ хийлгэхийг

⁷⁶ § 404a Abs. 1 ZPO § 404a ZPO - [Einzelnorm](#)

⁷⁷ § 405 ZPO § 405 ZPO - [Einzelnorm](#)

⁷⁸ § 286 Abs. 1 S. 1 ZPO § 286 ZPO - [Einzelnorm](#)

⁷⁹ § 409 Abs. 1 S. 1 ZPO § 409 ZPO - [Einzelnorm](#)

⁸⁰ § 409 Abs. 1 S. 3 ZPO § 411 ZPO - [Einzelnorm](#)

захирамжлах ба дахин, нэмэлт шинжилгээг хийлгэнэ. Мөн шинжээч дүгнэлтээ гаргасны дараа тухайн шинжээчээс татгалзах үндэслэл тогтоогдвол шүүх өөр шинжээчээр шинээр шинжилгээ хийлгэхийг захирамжилна.

Иргэний хууль. 839а дугаар зүйл. Шүүхийн шинжээчийн хариуцлага⁸¹. Энэ нь нарийвчилсан зохицуулалт байна. Шүүхээс томилогдсон шинжээч санаатайгаар буюу бүдүүлэг хайхрамжгүйгээр буруу дүгнэлт гаргасан бол, уг дүгнэлт дээр үндэслэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Хариуцлага хүлээгч нь зөвхөн шүүхээс томилогдсон шинжээч байх ба "хувь хүнийхээ" хувьд хариуцлага хүлээнэ. Шинжээчийн ажил олгогч (хуулийн этгээд) эсвэл хамтран ажилладаг бусад шинжээчид энэ заалтаар хариуцлага хүлээхгүй. Хэргийн оролцогч талын захиалгаар ажилласан "хувийн үнэлгээч" нь шүүхийн шинжээчид тооцогдохгүй. Шинжээчийн дүгнэлтэд бодит нөхцөл байдлыг буруу тогтоосон эсвэл зөв нөхцөл байдлаас буруу дүгнэлт хийсэн тохиолдолд буруу, ташаа байна гэж үзнэ. Жишээлбэл: Хэрэв үнэлгээчин буюу шинжээч орон сууцны үнийг буруу тооцвол ИХ-ийн 839а дугаар зүйлд дагуу буруу дүгнэлт гарсан гэж үзнэ. Гэсэн хэдий ч, дуудлага худалдаанд оролцогчийн үнэлгээнд үндэслэсэн үнэ зөв гэдэгт итгэх итгэл нь хамгаалагдахгүй; учир нь шинжээч нь дүгнэлтийнхээ эхлэлд буруу баримт ашигласан ч, эцсийн дүндээ гаргасан үнэлгээ нь зөв байвал шинжээч хариуцлага хүлээхгүй. Энэхүү заалтыг нэмж хуульчлахаас өмнө тангараг өргөөгүй шинжээч зөвхөн "санаатай" үйлдэлд хариуцлага хүлээдэг байсан бол тангараг өргөсөн шинжээч "хөнгөн болгоомжгүй" алдаанд ч эд хөрөнгийн хариуцлага хүлээдэг байсан бол одоо шинжээч хүн бүрийн мэдэж байх ёстой наад захын зүйлийг үл тоомсорлож, гаргасан алдаа нь ямар ч байдлаар залруулах боломжгүй байвал үүнийг "үлэмж болгоомжгүй" гэж үзнэ. Хэрэв хохирол амссан тал шүүхийн шийдвэрт гомдол гаргах замаар хохирлоос сэргийлэх боломж байсаар байтал өөрийн буруугаас гомдол гаргаагүй бол шинжээч хариуцлагаас чөлөөлөгдөнө. Нэхэмжилж буй хохирол нь тухайн буруу дүгнэлтэд үндэслэсэн шүүхийн шийдвэрээс шууд үүдэлтэй байх ёстой. Шүүхийн шийдвэрийн гол үндэслэл болсон шинжээчийн дүгнэлтэд гомдол гаргахаасаа өмнө процессийн бүх боломжит хууль ёсны арга хэрэгслийг ашигласан байна. Үүнд шинжээчийг шүүх хуралдаанд дуудах, аман

⁸¹ § 839a Absatz 1 BGB [§ 839a BGB - Einzelnorm](#)

тайлбар авахаар хүсэлт гаргах, ХБНГУ-ын ИХШХШ тухай хуулийн 411 дүгээр зүйлд заасны дагуу дүгнэлтийн алдааг зааж, шүүхэд албан ёсоор тайлбар, эсэргүүцэх байр сууриа илэрхийлсэн байна. Мөн тус хуулийн 412 дугаар зүйлд заасан шинээр шинжээч томилуулах, нэмэлт шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан байх⁸² зэрэг багтана⁸³.

2.3.3. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтыг МУ-тай харьцуулах нь

Хүснэгт 2. 2. *Хоёр улсын хууль тогтоомжийн харьцуулалт*

	Монгол Улс	ХБНГУ
Шинжээч томилох ажиллагаа	ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1	ИХШХШТХ-ийн 406 дугаар зүйл
	Хэргийн оролцогчдын хүсэлтийг үндэслэх ба зөвхөн шүүх томилж шүүгчийн захирамж гарна. Зохигч өөрийн дур зоргын дагуу шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах эрхгүй, тийм боломж байхгүй байдаг. Хуульд зааснаар тусгай мэдлэг шаардагдах асуудлыг хэрэг хянан шийдвэрлэх явцад тодруулахын тулд шинжээчийг томилно.	Шинжээчийг сонгох болон шинжээчдийн тоог тогтоох асуудлыг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх шийдвэрлэдэг ба тусгай мэдлэгийн хэрэгцээний хүрээнд шаардлагатай үйл баримтыг тодруулахын тулд томилно. Шинжээчийг томилохоос өмнө талуудаас тухайн шинжээчийн талаар саналыг сонсодог ба шүүх нь шинжээчээр ажиллахад тохирох этгээдийн нэрийг дэвшүүлэхийг талуудаас шаардаж болно. Хэрэв талууд тодорхой этгээдийг шинжээчээр томилох талаар харилцан тохиролцсон бол шүүх уг тохиролцоог заавал дагаж мөрддөг. Шинжээчид өгсөн зааварчилгааг шүүх талуудад мэдэгдэх ёстой ба хэрэв шинжээчид үүрэг даалгавар танилцуулах тусгайлсан тов тогтоосон бол талуудыг оролцохыг зөвшөөрдөг байна.
Шинжээчийн дүгнэлт	ШШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.	ИХШХШТХ-ийн 411 дүгээр зүйл.
	Шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангаж, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг хэлнэ ⁸⁴ .	Шинжээч өөрийн шинжлэн судалсан зүйл, судалгааны явц, ашигласан арга техник болон түүний үндсэн дээр гаргасан оюун дүгнэлтээ багтаасан бичмэл баримт бичгийг шинжээчийн дүгнэлт гэж хэлнэ.

⁸² § 412 Absatz 1 ZPO

⁸³ *Bundesamt für Justiz (Hrsg.): Staatshaftungsrecht und Spezialsuche, in: Gesetze im Internet, 2026, <https://www.gesetze-im-internet.de> (abgerufen am 19.04.2026).*

⁸⁴ ШШТХ(2022)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.

Шинжээчийн хариуцлага	Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4	ИХШХШТХ-ийн 409 дугаар зүйл
	Шинжээч шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд, эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд үнэн зөв дүгнэлт гаргахаа илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал дүгнэлт гаргасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ ⁸⁵ . Энэ нь Монгол Улсын хуульд заасны дагуу ХХША-ны эсрэг гэмт хэрэгт тооцогддог байна.	“Шинжээч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд ирээгүй, эсвэл дүгнэлт гаргах үүрэгтэй байсан ч татгалзсан, эсвэл хэргийн материал болон бусад баримт бичгийг буцааж өгөхгүй саатуулсан бол үүнээс үүдэн гарсан бүх зардлыг тухайн шинжээчээр төлүүлнэ”. Үүний зэрэгцээ түүнд сахилгын торгууль ногдуулдаг ⁸⁶ . Хэрэв уг зөрчлөө давтан гаргавал сахилгын торгуулийг дахин ногдуулж болно.
		ИХШХШТХ-ийн 411 дүгээр зүйл.
		Дүгнэлт гаргах үүрэг хүлээсэн шинжээч тогтоосон хугацааг хэтрүүлбэл түүнд сахилгын торгууль мөн ногдуулдаг. Торгууль ногдуулахаас өмнө шинжээчид нэмэлт хугацаа тогтоож, торгууль ногдуулахыг урьдчилан анхааруулсан байх ёстой. Хугацааг удаа дараа хэтрүүлбэл торгуулийг дахин ногдуулж болно. Нэг удаагийн торгуулийн хэмжээ 3000 еврогоос хэтрэхгүй байна.
		ИХ-ийн 839а дугаар заалт. Шинжээчийн хариуцлагын нарийвчлан зохицуулсан.

⁸⁵ ЭХ(2015)-ийн 21 дүгээр зүйлийн 21.4

⁸⁶ § 409 Abs. 1 S. 1 ZPO § 409 ZPO - [Einzelnorm](#)

		<p>Өмнө нь Германд шүүхийн шинжээчид зөвхөн "санаатайгаар" худал дүгнэлт гаргасан тохиолдолд хариуцлага хүлээдэг байсан бол 839а заалт орж ирснээр "үлэмж болгоомжгүй" үйлдэлд ч хариуцлага хүлээлгэдэг болсон. Шүүхээс томилогдсон шинжээч өөрийн үүргээ гүйцэтгэхдээ санаатайгаар эсвэл үлэмж болгоомжгүйгээр буруу дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтэд үндэслэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хохирсон хэргийн оролцогч талын хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p>
<p>Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх</p>	<p>ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2</p>	<p>ИХШХШТХ-ийн 286 дугаар зүйл. Нотлох баримтыг чөлөөтэй үнэлэх зарчим.</p>
	<p>Хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.</p> <p>Маргаангүй, эргэлзээгүй үйл баримтыг эхний ээлжинд шинжилгээний үндэс болгох</p> <ul style="list-style-type: none"> - Бүрэн бүтэн байдал - Үнэмшилтэй байдал - Эх сурвалжаа ил тод болгох, энэ нь ШУ-ны орчин үеийн стандартад нийцсэн эсэх - Мэргэжлийн ур чавдар, практик туршлага өндөр байх - Нөлөөлөлд автаагүй байх зэрэг багтана. 	<p>Шүүх нь ХХША-ны явцад цугларсан бүх нөхцөл байдал, агуулга болон нотлох баримтыг шинжлэн судалсан үр дүнг харгалзан үзэж, тухайн үйл баримт үнэн эсвэл худал болохыг өөрийн дотоод итгэлээр үнэлэн шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэрт шүүгчийн дотоод итгэл үнэмшил бүрдэхэд нөлөөлсөн үндэслэлүүдийг тодорхой зааж өгсөн байна. Мөн шинжээч дүгнэлтээ гаргасны дараа тухайн шинжээчээс татгалзах үндэслэл тогтоогдвол шүүх өөр шинжээчээр шинээр шинжилгээ хийлгэхийг захирамжилна. Шинжээчийн дүгнэлт нь шүүгчийн хувьд заавал дагаж мөрдөх "туйлын үнэн" биш, харин шүүгчийн үнэлэх ёстой нотлох баримтуудын л нэг юм. Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах зүйлсийг нягтална:</p> <ul style="list-style-type: none"> - Логик ба уялдаа холбоо - Шинжлэх ухааны үндэслэл - Бүрэн бүтэн байдал - Шинжээчийн ур чадвар

Шинжээчийн дүгнэлт гэдэг нь харьцуулан судалсан хоёр улсын хууль тогтоомжид заасны дагуу шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангаж, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг хэлнэ.

Монгол Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинжээчийн эрх зүйн байдлыг харьцуулан авч үзвэл Монгол Улсад шинжээчийг томилох ажиллагаа нь шүүгчийн захирамжаар хэрэгждэг үйл ажиллагаа байдаг бол ХБНГУ-ын ИХШХША-нд талуудын харилцан тохиролцоог нэн тэргүүнд тавьдаг нь иргэний процессын диспозитив зарчмыг илүү бодитой хэрэгжүүлж байна хэмээн харж болохоор байна Тухайлбал, ХБНГУ-ын шүүх шинжээчийг томилохдоо талуудын саналыг заавал сонсож, хэрэв оролцогчид тодорхой мэргэжилтэн дээр санал нэгдсэн бол шүүх тэрхүү шийдвэрийг дагах үүрэг хүлээдэг нь шинжээчийн гаргах дүгнэлтэд итгэх талуудын итгэлийг урьдчилан баталгаажуулахаар зогсохгүй цаашид шинжээчийг аль нэг талтай ашиг сонирхлын зөрчилтэй байсан гэх маргааныг хааж өгдөг хэмээн үзэж байна.

Хариуцлагын тогтолцооны хувьд Монгол Улс шинжээчийг санаатайгаар худал дүгнэлт гаргахаас сэргийлэхдээ Эрүүгийн хуулиар зохицуулдаг буюу хорих, зорчих эрхийг хязгаарлах зэрэг санкциуд багтдаг. Харин ХБНГУ-ын шинжээчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо нь эрүүгийн хариуцлагаас илүүтэйгээр эдийн засгийн болон процессын хариуцлагад илүү ач холбогдол өгдгөөрөө онцлогтой гэж дүгнэж байна. Германы ИХШХШТХ-ийн 409 болон 411 дүгээр зүйлд зааснаар шинжээч шүүхэд ирээгүй, дүгнэлт гаргахаас татгалзсан эсвэл хугацаа хэтрүүлсэн тохиолдолд шүүхээс мөнгөн торгууль ногдуулж, үүнээс үүдэн гарсан бүх зардлыг шинжээчээр төлүүлдэг нь шинжээч томилохоос эхлээд дүгнэлт гарах, шүүхэд дүгнэлтийг ирүүлэх бүхий л процесст шинжээчийн хариуцлагыг нарийвчлан тусгаж өгчээ. ХБНГУ-ын ИХШХШТХ-д заасан хариуцлагаас гадна Иргэний хуульд заасан гол зохицуулалт болох Иргэний хуулийн 839а дүгээр зүйл нь шинжээчийн мэргэжлийн хариуцлагыг илүү өнлөржүүлсэн, худал дүгнэлт гаргах эрсдлийг багасгахад чиглэсэн зохицуулалт байна. Энэ нь шинжээч зөвхөн санаатайгаар бус, бүр "үлэмж болгоомжгүй" байдлаар буруу дүгнэлт гаргаж, түүний улмаас талуудын аль нэгэнд хохирол учирсан бол шинжээч өөрийн хөрөнгөөр уг хохирлыг хохирол учирсан талд бүрэн барагдуулах үүрэг хүлээдэг. Энэхүү эд хөрөнгийн хариуцлага нь шинжээчдийг мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хариуцлагатай байлгах тал дээр анхаарсан, хохирсон талын эрх ашгийг хамгаалах зохицуулалт байна.

ДУГНЭЛТ

Шинжээчийн дүгнэлт нь ИХШХША-ны тусгай мэдлэг шаардсан үйл баримтыг тогтоох нотолгооны хэрэгсэл юм. Энэ нь шүүгчийн эзэмшээгүй нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвар шаардах хэрэгт ач холбогдолтой нотолгооны зүйлийг тогтооход чиглэсэн ажиллагаа байна. Шинжээчийн дүгнэлт нь нотлох ажиллагааны эх сурвалж болдог боловч бусад нотлох баримтаас давуу эрхтэй гэсэн ойлголт биш. Шүүх шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримттай тал бүрээс нь харьцуулан шинжэлсний үндсэн дээр шийдвэр гаргадаг. ИХШХШТХ-ийн дагуу шинжээчийг зохигчийн хүсэлтээр томилох ба нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа, хариуцагч хариу тайлбараа нотлох үүргийг хүлээнэ. Энэ нь хуульд заасан мэтгэлцэх болон диспозитив зарчимд нийцдэг. Шинжээчийг томилох нь хэргийн оролцогчийн хүсэлтэд үндэслэдэг боловч дүгнэлт эргэлзээтэй эсвэл зөрүүтэй гарсан тохиолдолд шүүх дахин болон нэмэлт шинжилгээ хийлгэх эрхтэй байна. Шинжээч нь тухайн асуудлаар мэргэшсэн, ашиг сонирхлын зөрчилгүй этгээд байх бөгөөд зориуд худал дүгнэлт гаргавал эрүүгийн хуульд заан хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалттай. Зөвхөн шүүгчийн захирамжаар томилогдсон шинжээчийн ирүүлсэн дүгнэлтийг шинжээчийн дүгнэлт гэж үзэх бөгөөд бусад тохиолдолд бичмэл нотлох баримтын хүрээнд үнэлдэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлт нь маргааны төрөл, материаллаг эрх зүйн зохицуулалтын шинж чанараас хамааран харилцан адилгүй байр суурь, нотлох үүргийг гүйцэтгэж байна. Гэр бүлийн маргаан дахь эцэг тогтоох шинжилгээний хувьд орчин үеийн шинжлэх ухаан нь эцэг мөн биш байх алдааны магадлалыг 2 хувьд багтаадаг тул Д.Алтантуул шүүгчийн дурдсанчлан шүүх практикт үүнийг шууд эргэлзээгүй нотлох баримтаар тооцон үнэлж байна. Энэ нь онолын хувьд шинжлэх ухааны батлагдсан үр дүн шүүгчийн субъектив дотоод итгэл үнэмшлээс давуу эрхтэй боловч процессын эрх зүйн хувьд ямар ч нотлох баримт шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон баримт биш бөгөөд шүүгч түүнийг үндэслэлтэй байдлынх нь хувьд заавал шалгах үүрэгтэй байдаг. Үүний эсрэгээр хүүхдийн асрамж тогтоолгох маргааны хувьд Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.16-д заасан хүүхдийн нас, эцэг эхийн халамж, ахуйн нөхцөл, боллоцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг тогтооход шинжээчийн дүгнэлт нь шийдвэрлэх бус, харин нотлох баримтын эх сурвалжийн үүргийг гүйцэтгэж, шүүх гэр

бүлийн тухай хуульд заасны дагуу 7 насанд хүрсэн бол хүүхдийн мэдүүлгийг нотлох баримт болгон голчлон үндэслэдэг байна.

Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн дагуу ажил гүйцэтгэх гэрээний маргаанд "яг ямар үр дүн гарсан бэ, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанар хангалттай байсан уу" гэдгийг тогтооход, эсхүл ИХ-ийн 497, 510 дугаар зүйлд заасан гэм хор учруулснаас үүсэх хариуцлагын маргаанд хохирлын бодит хэмжээ, мөнгөн дүнг тодорхойлоход нэхэмжлэгч өөрт хохирол учирсан гэдгийг мэдэж байгаа хэдий ч тухайн хохирлын мөнгөн дүнг өөрөө тооцоолох боломжгүйгээс шалтгаалан мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулах хэрэгцээ шаардлага үүсдэг. Түүнчлэн ИХ-ийн 520, 523 дугаар зүйлд заасан өвийн маргаанд гар бичмэл гэрээслэлийн жинхэнэ эсэхийг тогтоох болон ИХ-ийн 177.1, ШШГТХ-ийн 55.7-д зааснаар дуудлага худалдааны доод үнийг тогтоох шийдвэр гүйцэтгэлийн шатанд шинжээч нь томилсон этгээдийн тогтоолд заасан асуултын хүрээнд шинжилгээ хийх үүрэгтэйгээр оролцож байна. Шинжээч нь онолын хувьд шүүгчийн туслах нотолгооны хэрэгсэл болохоос, хэргийг эцэслэн шийдэхгүй учир шүүх гарын үсэг хуурамч болох нь энгийн нүдээр харахад илэрхий байсан ч мэргэжлийн дүгнэлтээр баталгаажуулж байгаа нь нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэх хууль ёсны шаардлагыг хангах үндэслэл болдог. Талуудын хүсэлтэд тулгуурлан шинжээч томилох нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимтай нийцэж байгаа хэдий ч шүүхээс эрх зүйн туслалцаа үзүүлэх замаар талуудын мэдлэгийн дутмаг байдлыг нөхөж, шинжээч томилуулах тухай санаачилгыг өгч байгаа нь хэргийн үнэн зөв байдлыг тогтоох чухал арга хэмжээ юм. Гэхдээ шинжээч хүсэлт болгоныг шүүх хангаж шийдвэрлэх боломжгүй бөгөөд тухайн нотолгооны зүйлийн эргэлзээг тайлах нь хэрэгт хэр их ач холбогдолтойг үндэслэн шүүгчийн захирамжаар шийдвэрлэдэг болох нь хүсэлт шийдвэрлэсэн шүүгчийн захирамжуудаас харж болно.

ИХШХШТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.1-д зааснаар иргэний хэргийг хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол 30 хоногийн дотор шийдвэрлэхээр хуульчилсан боловч сүүлийн жилүүдэд шүүхийн ачаалал нэмэгдсэн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ажиллагаа удааширч, үүний нэг гол шалтгаан нь шинжээчийн дүгнэлт хугацаандаа ирэхгүй байх, нэмэлт болон дахин шинжилгээ хийх явдал болж байна.

Практикт хөрөнгийн үнэлгээний нэгдмэл биш байдал, эдийн болон эдийн бус хөрөнгийн үнийг тогтоосон баримтлах жишиг дутмаг байдгаас үүдэн талууд үнэлгээний дүнтэй ихээхэн маргаж, хэрэг улам удааширдаг байна.

Шүүгч дотоод итгэлээрээ шинжээчийн дүгнэлтийн логик уялдааг шалгах явцад дараах дутагдал илэрвэл шийдвэрийн үндэслэл болгохгүй хасдаг. Үүнд, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар шинжээчид "Худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуулийн 21.4-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэдгийг урьдчилан сануулж гарын үсэг зуруулаагүй бол, эсхүл ИХШХШТХ-ийн 26-р зүйлд заасан татгалзан гаргах нөхцөл байдал илэрсэн, мөн тусгай мэдлэгийн эрхгүй этгээд дүгнэлт гаргасан бол шүүх үүнийг шууд үнэлэхгүй хасдаг байна. Агуулгын хувьд шинжээчийн дүгнэлтийн судалгааны хэсэг нь төгсгөлийн нэгдсэн хариулттайгаа зөрчилдсөн, эсхүл шинжлэх ухааны баримт тооцоололгүйгээр ерөнхий таамаг дэвшүүлж эргэлзээтэй бичсэн бол, түүнчлэн хэргийн оролцогч уг дүгнэлтийг няцаасан өөр хууль ёсны баримт гаргаж өгөх буюу шинжээчийн ашигласан аргачлал буруу байсныг нотолж чадвал шүүх дүгнэлтийг үнэлэхгүй байх эрхтэй бөгөөд энэ нь дахин шинжилгээ хийлгэх үндэс болдог.

Монгол Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинжээчийн эрх зүйн байдлыг харьцуулан авч үзвэл Монгол Улсад шинжээчийг томилох ажиллагаа нь шүүгчийн захирамжаар хэрэгждэг төрийн хяналтын шинжтэй үйл ажиллагаа байдаг бол ХБНГУ-ын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын харилцан тохиролцоог нэн тэргүүнд тавьдаг нь процессын диспозитив зарчмыг илүү бодитой хэрэгжүүлдэг. Германы шүүх шинжээчийг томилохдоо талуудын саналыг заавал сонсож, хэрэв оролцогчид тодорхой мэргэжилтэн дээр санал нэгдсэн бол шүүх тэрхүү шийдвэрийг дагах үүрэг хүлээдэг нь шинжээчийн гаргах дүгнэлтэд итгэх талуудын итгэлийг урьдчилан баталгаажуулахаас гадна цаашид шинжээчийг ашиг сонирхлын зөрчилтэй байсан гэх маргааныг хааж өгдөг давуу талтай. Хариуцлагын тогтолцооны хувьд Монгол Улс шинжээчийг санаатайгаар худал дүгнэлт гаргахаас сэргийлэхдээ зөвхөн Эрүүгийн хуулиар зохицуулдаг бол ХБНГУ-д эрүүгийн хариуцлагаас илүүтэйгээр эдийн засгийн болон процессын хариуцлагад илүү ач холбогдол өгдөг. Германы ИХШХШТХ-ийн 409, 411 дүгээр зүйлд зааснаар шинжээч шүүхэд ирээгүй, дүгнэлт гаргахаас татгалзсан эсвэл хугацаа хэтрүүлсэн тохиолдолд шүүхээс мөнгөн торгууль ногдуулж, үүнээс үүдэн гарсан бүх зардлыг шинжээчээр

төлүүлдэг нь процессын хариуцлагыг нарийвчлан зохицуулсныг илтгэнэ. Хамгийн гол зохицуулалт болох Германы Иргэний хуулийн 839а дүгээр зүйл нь шинжээчийн мэргэжлийн хариуцлагыг өндөржүүлсэн бөгөөд шинжээч зөвхөн санаатайгаар бус, бүр "үлэмж болгоомжгүй" байдлаар буруу дүгнэлт гаргаж, түүний улмаас талуудын аль нэгэнд хохирол учирсан бол шинжээч өөрийн хувийн хөрөнгөөр уг хохирлыг хохирол учирсан талд бүрэн барагдуулах үүрэг хүлээдэг байна. Энэхүү эд хөрөнгийн хариуцлага нь шинжээчдийг мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хариуцлагатай байлгахаас гадна худал дүгнэлт гаргах эрсдэлийг бууруулж, хохирсон талын эрх ашгийг хамгаалдаг дэвшилтэт чухал зохицуулалт байна хэмээн үзэж байна.

САНАЛ

Санал 1.

Практикт хөрөнгийн үнэлгээ, ажил гүйцэтгэх гэрээ, гэм хорын хохирлын хэмжээний маргаанд шинжээчдийн дүгнэлт хэт зөрүүтэй ирдэг нь талууд гомдол гаргах, нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэж хэргийг сунжруулах шалтгаан болж байна. Энэ нь үнэлгээний нэгдмэл жишиг баримтлах баримт бичиг, үнийг тогтоосон журам байхгүйтэй холбоотой гэж үзэж байна.

- Иргэний маргаанд түгээмэл хэрэглэгддэг эд хөрөнгө болох автомашин, үл хөдлөх хөрөнгө, барилгын материалын өртөг зэргийнхний улирал тутмын жишиг үнийн сантай болох.

Санал 2.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль талууд харилцан тохиролцож шинжээчийг сонгох эрхийг хуульчлах нь тохиромжтой. Хэргийн оролцогч талууд тусгай мэдлэг бүхий тодорхой мэргэжилтэн, шинжээчийг томилуулахаар харилцан тохиролцож, саналаа шүүхэд гаргасан тохиолдолд шүүх тухайн этгээдийг шинжээчээр томилно. Талууд харилцан тохиролцож сонгосон шинжээчийн дүгнэлтийн аргачлал, үр дүнтэй холбогдуулан дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах эрхийг хязгаарлаж болохоор байна хэмээн үзэж байна. Энэ нь шин жээчийн дүгнэлт гарсны дараа ашиг сонирхлын зөрчилтэй этгээд шинжээчээр томилсон, дүгнэлт гарсан, хүчингүй болгуулах зэрэг асуудлыг багасгаж болно.

Санал 3.

Монгол Улсад шинжээчийн хариуцлагыг зөвхөн Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт санаатай худал дүгнэлт гаргах гэж заасан байна. Гэвч практикт шинжээчийн мэргэжлийн ур чадвар дутмаг, хариуцлагагүй, хайхрамжгүй байдлаас үүдэж буруу үнэлгээ, дүгнэлт гарснаар ХХША удаашрах, шинжээчийн зардал нэмэгдэх зэрэг асуудлууд байна. Эрүүгийн хуулиас гадна Шүүх шинжилгээний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэгт шинжээчийн хариуцлагын талаар нарийвчилсан заалт байхгүй байна.

- ХБНГУ-ын ИХШХШТХ-д заасанчлан шинжээч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд ирээгүй, эсвэл дүгнэлт гаргах үүрэгтэй байсан ч татгалзсан, эсвэл хэргийн материал болон бусад баримт бичгийг буцааж өгөхгүй саатуулсан бол үүнээс үүдэн гарсан бүх зардлыг тухайн шинжээчээр төлүүлэх

зохицуулалт, тогтоосон хугацааг хэтрүүлбэл түүнд сахилгын торгууль мөн ногдуулдаг зохицуулалтыг ИХШХШтХ-д тусгаж өгөх.

- Нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх шаардлага өмнөх шинжээчийн дутуу болон алдаатай дүгнэлтээс үүдсэн нь тогтоогдсон тохиолдолд уг нэмэлт шинжилгээний зардлыг өмнөх шинжээчид хариуцуулах зохицуулалтыг ШШтХ-д нэмж оруулах

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Иргэний хууль, 2002 он
3. Эрүүгийн хууль, 2015 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
5. Зөрчлийн тухай хууль, 2017 он
6. Шүүх шинжилгээний тухай хууль, 2022 он
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он
8. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, 2022 он
9. Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт, 2008 он
10. Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны шинжээчийн дүгнэлтийн анхаарах зарим асуудал, 2014 он
11. Улсын Дээд Шүүхийн зөвлөмж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд нотлох баримтыг үнэлэх шүүгчийн ажиллагаа, 2008 он
12. Хууль зүй дотоод хэргийн сайд, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/158 дугаар тушаалын хавсралт Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах, орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

13. Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний процесс дахь нотолгооны эрх зүй*, 2024 он
14. Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, 2021 он
15. Монгол Улсын Дээд Шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, 2008 он
16. Т.Мөнхжаргал, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, 2008 он
17. Жадамбын Наранцацрал, Авирмэдийн Дугармаа, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, 2007 он
18. Тогоохүүгийн Очирбат, *Шүүх шинжилгээний хөтөч*, 2013 он

19. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”, 2015 он
20. Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв, “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь”, 2023 он
21. Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал”, 2015 он

3. Цахим эх сурвалж:

22. Монгол улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: [Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем](#)
23. Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан: [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)
24. Шүүхийн ерөнхий зөвлөл: [ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ](#)
25. Германы хууль зүй, хэрэглэгчийн эрхийг хамргаалах яамны албан ёсны цахим хуудас: [BMJV - Bundesministerium der Justiz und für Verbraucherschutz](#)
26. Герман улс дахь газрын үнэлгээ, мэдээллийг нэгтгэн оруулдаг албан ёсны нэгдсэн систем: [Verkehrswert Immobilie: Ermitteln Sie den realen Wert](#)
27. Герман улсын төрийн хариуцлагын талаарх мэдээллийн систем: [Staatshaftungsrecht und Spezialsuche - Staats-Haftung](#)